

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 08 сар. №16 (026)

Эх оронч ус

Байгаль өөрөө шүүгч нь

2012 оны дэлхийн “гайхамшгууд”

www.mongolianeconomy.mn

НОГООН ХӨГЖИЛД ТИЙМ ГЭЖ ХЭЛЭЭЧ



ВАГНЕР АЗИ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК

БУТЛАХ, ШИГШИХ, POWERSCREEN ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨС ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

Загвар: Шигшигч Chieftain 1700 3 Deck



Бүтээгдэхүүний гарцын хүчин
чадал: 500 тонн/цаг хүртэл

Хөдөлгүүрийн хүчин чадал:
Caterpillar C4 83Kw 111.3HP

Жин: 33 тонн

Шатахууны савны багтаамж:
336 литр
Шатахуун зарцуулалт: 18 л/цаг

Загвар: Хацарт бутлуур-ХА 400S Jaw Crusher



Бүтээгдэхүүний гарцын хүчин
чадал: 230 тонн/цаг хүртэл
Хөдөлгүүрийн хүчин чадал:
Caterpillar C-9 250 Kw 335 HP
Жин: 32 тонн
Шатахууны савны багтаамж:
522 литр
Шатахуун зарцуулалт: 36 л/цаг



Бүтээгдэхүүний гарцын хүчин
чадал: 400 тонн/цаг хүртэл

Хөдөлгүүрийн хүчин чадал:
Caterpillar C9 172 Kw 230HP

Жин: 45 тонн

Шатахууны савны багтаамж:
400 литр
Шатахуун зарцуулалт: 35 л/цаг



Загвар: Хацарт бутлуур-ХА 400S Jaw Crusher



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

НАРРУУ VACATION

Хаана ч хамтдаа
ХАМГИЙН найдвартай



ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ОЛОН УЛСЫН КАРТУУД



ХӨНГӨЛӨЛТТЭЙ БОЛОН ҮНЭГҮЙ
 АВАХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД:

- ★ iBANK ҮЙЛЧИЛГЭЭНД ҮНЭГҮЙ БҮРТГЭХ
 /Дансны үлдэгдэл, Дансны хуулга, Ханшийн мэдээг
 хаанаас ч үнэгүй авах боломж/
- ★ МЕССЕЖ БАНК ҮЙЛЧИЛГЭЭНД ҮНЭГҮЙ БҮРТГЭХ
 /Дансанд орлого, зарлага орох үед таны утсанд
 мэдээлэл мессеж ирнэ/
- ★ VISA, MASTERCARD-С ДЭЛХИЙ ДАЯАР
 ЗАРЛАСАН ТӨРӨЛ БҮРИЙН УРАМШУУЛЛЫГ
 ХХБ-НЫ КАРТААР АВАХ БОЛОМЖТОЙ

☎ 1977
 🌐 www.tdbm.mn
 @ info@tdbm.mn
 📘 http://www.facebook.com/TDBInt.LCard

METALS MONGOLIA 2012

Policy - Investments - Technology - Environment

Second International Conference of Mining and Metallurgy
УУЛ УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН
ХОЁРДУГААР ЧУУЛГАН

Organizers:



MINERAL RESOURCES
AUTHORITY



MONGOLIAN MINING PORTAL - MINING.mn
(MAIN ORGANIZER)

ХУРЛЫН БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ

2012 оны 11 сарын 08-09
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

08-09th November, 2012
ULAANBAATAR, MONGOLIA



For more information and to register please visit
www.metalsmongolia.mn, Tel: +976-70115590
E-mail: info@mining.mn info@metalsmongolia.mn

МОНГОЛ УЛСАД УУЛ УУРХАЙН САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 90 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД

MONGOLIAN MINING DIRECTORY 2013



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ - 2013

**МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА БАЙРШУУЛАХ
ЗАХИАЛГА АВЧ БАЙНА**

ЗАХИАЛГА
ДУУСАХАД
45 ХОНОГ
ҮЛДЛЭЭ

Дэлгэрэнгүй мэдээллийг

70115590

www.mining.mn



Холбоо барих:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, МҮЭСТО-200 тоот

Утас: +976-70115590, Факс: +976-70125590

И-мэйл: jargal@mining.mn, Веб: www.mining.mn

Ногоон хөгжлийн пөлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ВЭБ РЕДАКТОР Б.Энхмарт

ОРЧУУЛАГЧ: Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь

ПРОГРАММИСТ: Н.Түвшинбаяр

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР:

Ж.Алтантуяа /9905-1914/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Бариянжав /8880-0825/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш

"ECONOMY" ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ: Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

АЙДЕОӨӨЛӨ ОҮА А:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетиин бүх салбар

"Макс" супермаркетиин бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүриин номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүриин

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall"

"MONGOLIAN ECONOMY"

СЭТГҮҮЛ

ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ТАНЫ ОЮУНД

<http://mongolianeconomy.imedia.mn>

"Өөрийн үйлдвэр" ӨӨЭ-а буюу

www.ubprint.mn

Ногоон өсөлт




Дэлхий дахинаа шинэ хөгжлийг бий болгоход чиглэсэн олон хурал, семинар болдог болжээ. Тэдгээрийн нэг нь өнгөрсөн тавдугаар сард Сөүл хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн ногоон өсөлт-2012” уулзалт юм...11

Эх оронч ус

Ус хэдийгээр “Эх орныхоо төлөө зүтгээ” гэж хэлж чадахгүй ч бид Монгол Улсынхаа хөгжлийн төлөө ус гэгч чандмань эрдэнийг ашиглаж болох. Гэхдээ яаж?...15



Сэргээгдэх эрчим хүч рүү хүрэх гүүр



Нүүрсний хэрэглээг багасгах боломж бий. Үүнийг дэлхий дахинаа хавсарсан технологи гэж нэрлэдэг аж. Одоогоор уг технологи өргөн тархаагүй ч амжилттай хэрэгжиж байгаа юм...17

2012 оны дэлхийн гайхамшгууд

Таны хүсэл сонирхлыг 2012 онд ямар газрууд урин дуудаж байна вэ. Америкийн National Geographic сувгаас эрхлэн гаргадаг “Traveler” буюу “Аялагч” сэтгүүлээс энэ жил дэлхийн хүмүүсийн анхаарлыг хамгийн их татаж буй 20 орныг нэрлэжээ...23



ногоон эдийн засаг



- 10 Шинэ Засаг ба Ногоон бодлого
- 11 Ногоон өсөлт
- 15 Эх оронч ус
- 17 Сэргээгдэх эрчим хүч рүү хүрэх гүүр
- 20 Байгаль өөрөө шүүгч нь
- 23 2012 оны дэлхийн “гайхамшгууд”
- 28 Ёс зүй төлөвшихгүй, ёс суртахуун төлөвшинө

Нийгэм

- 30 Эрүүл амьдрахын нууц эрүүл шүд
- 32 Европын нийгмийн загвар гэж юу вэ?

Бизнес

- 33 Компанийн нийгмийн хариуцлага маркетингийн арга хэрэгсэл биш
- 37 Шинэ ном

ИНФЛЯЦИ

Эх сурвалж: Монголбанк

Бага орлоготой иргэдийн хүнсний хэрэглээний нийт зардал нь нийт орлогын 50 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, олсон орлогынхоо тал хувийг зөвхөн хүнсний хэрэгцээндээ зарцуулж байна гэсэн үг. Иймэрхүү орлогын түвшин тааруухан өрхөд инфляцийн бодит нөлөөлөл нь 50-60 хувь байна хэмээн Монголбанкныхан “Эдийн засгийн аюулгүй байдал ба нийгмийн дундаж давхарга” гэсэн судалгаандаа онцолжээ. Харин дундаж орлоготой иргэдийн хүнсний хэрэглээний нийт зардал 35 хувь бол инфляцийн бодит нөлөөлөл нь 20-30 хувь байдаг байна. Тэгвэл өндөр орлоготой иргэдэд инфляцийн бодит нөлөөлөл 2-3 хувиар нөлөөлдөг аж.

УУРХАЙ

Газрын тосны газраас Газрын тосны хайгуулын Чойр-XXV талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий аж ахуйн нэгжийг захиалгаа ирүүлж, сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна. Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын нэгдүгээр хавсралтын дагуу танилцуулгыг, хоёрдугаар хавсралтын дагуу захиалгын материалыг бэлтгэн, Чойр-XXV талбайн геологийн багц мэдээлэл худалдан авсан, захиалгын үйлчилгээний шимтгэл төлсөн баримтын хамт тус газарт материалаа ирүүлэх аж. Одоогийн байдлаар эхний танилцуулга ирээгүй тул сонгон шалгаруулалтын

УУЛ

хаалтын хугацаа тодорхойгүй байна. Эхний танилцуулга ирснээс хойших 30 хоногийн дотор шалгаруулалтын хаалтын хугацааг олон нийтэд зарлах аж.

TATBAP

Татварын ерөнхий газар таван жилийн өмнөөс аж ахуйн нэгжийн тайланг цахим хэлбэрээр хүлээж авч эхэлсэн билээ. Тэгвэл өнгөрсөн оны сүүлчээр Цахим гарын үсгийн тухай хуулийг баталсантай холбоотойгоор тоон гарын үсгийн системийг өнгөрсөн зургадугаар сараас орон даяар ашиглаж эхэллээ. Одоогоор 50 орчим аж ахуйн нэгж тоон гарын үсгийн системийг ашиглаж, тайлангаа нууцлалтай явуулсан байна. Ирэх оны нэгдүгээр сарын 1-нээс хуулиараа тоон гарын үсгийн системийг бүх байгууллага ашиглаж эхлэх аж. Ингэснээр тайлангаа хүлээлгэж өгсөний дараа татварын газарт ирж гарын үсэг зурдаг хүндрэл арилах юм байна. Хэрэв танай компани тоон гарын үсгийг сонирхож байгаа бол Татварын ерөнхий газарт хандан хувийн болон нийтийн гэсэн хоёр түлхүүрийн тэмдэглэгээ авч, тайлангаа цахимаар явуулах боломжтой аж. Мөн Татварын ерөнхий газар, “Монгол шуудан” банктай хамтарч аж ахуйн нэгжийн тайланг шуудангаар хүлээж авч эхэлжээ. Ингэхдээ аж ахуйн нэгж тайлангаа явуулахдаа шуудандаа 2000

төгрөг төлж, холбогдох байгууллагынхаа хаяг, байршил, утасны дугаарыг тодорхой бичиж явуулах хэрэгтэй юм байна.

БИЗНЕС

Хятадын Баруун бүсийн Олон улсын үзэсгэлэн яармаг БНХАУ-ын Сичуань мужийн Ченг-Ду хотноо ирэх сарын 25-30-нд болох гэж байна. Тус үзэсгэлэнг БНХАУ-ын 15 яам, Байнгын хороо, бүс нутгийн 12 муж Шиньжааны үйлдвэрлэл, барилгын корпораци хамтарч зохион байгуулж буйгаараа онцлог аж. Бүс нутагтаа нэр хүнд, хамрах цар хүрээгээрээ дээгүүр бичигддэг тус үзэсгэлэнд 52 орны 5000 орчим байгууллага оролцох юм байна. Ингэхдээ өндөр технологи, электрон, цахим мэдээлэл, тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй гэсэн салбарынхан үзэсгэлэнд түлхүү оролцож буй юм. Үзэсгэлэнгийн үеэр Хятадын баруун бүс нутгийн хамтын ажиллагааны болон Санхүүгийн форум зэрэг олон улсын хөрөнгө оруулалт, худалдаа хамтын ажиллагааг дэмжсэн цөөнгүй арга хэмжээ болох аж. Харин манай улсаас тус үзэсгэлэнд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгж, хувь хүмүүс ирэх сарын 10-ны дотор МҮХАУТ-д хандан бүртгүүлэх боломжтой.

АЖ ҮЙЛДВЭР

“Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор”-т нийтдээ 9.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай

аж. Тэгвэл дээрх хөрөнгийн эх үүсвэрт Хөгжлийн банк санаа тавих бөгөөд төр хувийн хэвшлийн хөрөнгөөр бүтээн байгуулалтыг эхний ээлжинд эхлүүлэх юм байна. Сайншандад 20 сая тоннын хүчин чадалтай, Тавантолгойгоос түүхий эдээ татах Коксын үйлдвэрийг барихаар тооцжээ. Тус үйлдвэрийг байгуулахад 1.8 тэрбум ам.доллар шаардлагатай бөгөөд бүтээн байгуулахад 36 сарын хугацаа шаардлагатай аж. Мөн 1.7 тэрбум ам.долларын өртөгтэй Зэс хайлуулах үйлдвэр, 4.5 тонн хүчин чадалтай Үрлэн төмөр, 315 сая ам.долларын зардал бүхий Цементийн үйлдвэр тус тус барихаар болжээ. Хар төмөрлөгийн үйлдвэрийг Дарханд, газрын тосны үйлдвэрийг бүсчилсэн байдлаар барих нь эдийн засгийн ашигтай хэмээн үзсэн байна. Аж үйлдвэрийн цогцолборт нийтдээ 2100 гаруй тогтмол ажлын байр шинээр бий болох аж.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ҮХШХ-ноос хэрэгцээтэй буй инженер техникийн ажилтны эрэлтийн судалгааг гаргажээ. Судалгаанаас үзэхэд манай оронд ойрын таван жилд нийтдээ 4774 хүнийг баклавар, 250 хүнийг мастерт инженерийн чиглэлээр сургах шаардлагатай аж. Тухайлбал, Сайншанд аж үйлдвэрийн цогцолборт л гэхэд 543 инженер техникийн ажилтны эрэлт хэрэгцээ байна. Дашрамд өгүүлэхэд Япон Улсын

хамтын ажиллагааны нийгэмлэгээс /JICA/ Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор 460 оюутныг урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн тэтгэлэгт хамруулж суралцуулах саналыг манайд тавьжээ.

ОРОС

ОХУ олж илрүүлээд буй цагаан алт, алмааз, алт тэргүүтэй стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын олборлолтоо хөгжүүлэх зорилгоор гадаадын компаниудыг тус улсын нутаг дээр геологийн хайгуул, олборлолт хийх ажлыг албан ёсоор дэмжихээр болжээ. Тус улсын Ашигт малтмалын яамнаас нээж илрүүлээд байгаа стратегийн орд газрууд дээр гадаадын уул уурхайн компаниуд үргэлжлүүлэн ажиллахыг

одоогийн хуулиар хүчин төгөлдөр болгож, засвар хийхээр бэлдэж байгаа юм байна. Өмнөх хуулиараа хойд хөршийн Засгийн газар үндэсний аюулгүй байдалд харшилж байна гэж үзвэл гадаадын ямар ч компанийн тус улсын газар нутаг дээрх уул уурхайн олборлолтыг түтгэлзүүлэх эрхтэй байсан билээ. Оросын дээрх шинэ хууль дүрмүүд нь ашигт малтмалын асар том зах зээлд гадаадын хөрөнгө оруулалтыг соронзон мэт татна хэмээн найдаж байгаа юм. Тус улсад үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын компаниуд ч энэ хуулийг ихээхэн дэмжиж байна.

ХЯТАД

Хятадын экспортын өсөлт энэ оны долдугаар сард их хэмжээгээр унасантай холбогдуулан импортын хэмжээ болон шинээр олгож эхэлсэн юанийн зээл ч тэр дагаад урууджээ. Тус улсын

гадаадын улс орнууд руу гаргадаг ачаа тээвэрлэлт энэ оны зургаадугаар сард 11.3 хувиар өссөн дүнтэй гарч байсан бол долоодугаар сард ердөө л нэг хувиар өссөн гэдгийг Хятадын Гаалийн албанаас мэдээлсэн байна. Харин дотоодын мөнгөн тэмдэгтээр олгож эхэлсэн шинэ зээлийн хувьд зуны эхэн сард 919.8 тэрбум юань байсан авч зуны дунд сард буюу долдугаар сард 540.1 тэрбум юань болтлоо буурсан болохыг тус улсын Төвбанк мэдэгдсэн юм. Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийн бүтээмж санаанд оромгүйгээр уруудаж жилийн эхэн үетэй харьцуулахад 9.2 хувь болтлоо унасан байна. Энэ оны эхэнд Хятадын худалдааны ашиг 31.5 тэрбум ам.доллартай тэнцэж байсан бол өнгөрсөн сард 25.1 тэрбум ам.доллар болжээ.



Шог зургийг А.Амарсайхан



ШИНЭ ЗАСАГ БА НОГООН БОДЛОГО

тарих биз ээ.

Мөн Монгол Улсын шинэ Ерөнхий сайд Н.Алтанхуяг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн төсөлд 16 яамтай байх санал өгсөн бөгөөд түүний дотор Байгаль орчин, ногоон хөгжлийн яам гэсэн статус гаргаж ирсэн нь онцлох мэдээ байв. Энэ нь одоогоор /2012.08.14/ албан ёсоор баталгаажаагүй бөгөөд Байгаль орчны яамтай ногоон хөгжлийн бодлогыг холбох нь зүйн хэрэг билээ. Түүнчлэн урьдчилсан таамгаар тус салбарын сайдад УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлийн нэр яригдаж байгаа нь ногоон хөгжлийн асуудлуудыг төрийн бодлогод суулгуулахад нэмэртэй байх талтай. БОАЖ-ын одоогийн сайд Д.Цогтбаатар ч сүүлийн хагас жилийн хугацаанд байгаль орчин, ногоон эдийн засгийн чиглэлээр багагүй дуу хоолой гаргаж, санал санаачилга, зоримог шийдвэртэй ажиллаж буй буйг тэмдэглэх хэрэгтэй болов уу.

Мөн Байгаль орчны багц хууль энэ онд батлагдсан нь байгаль орчны салбарт гарсан дэвшил гэж хэлж болох. Учир нь, Байгаль орчны салбарын голлох суурь хуулиуд 1990-ээд оны дундуур батлагдаж, түүнээс хойшхи хугацаанд бодлогын дорвитой өөрчлөлт ороогүй байсан юм. Өнөөг хүртэл мөрдөгдөж ирсэн 30 гаруй хуулиар байгаль орчин хамгааллын бүх хариуцлагыг төр дангаараа үүрч байв. Энэ зохицуулалтыг өөрчилж, бохирдуулагч нь төлбөр төлөгч байх, ашиглагч нь хамгаалагч байх суурь зарчимд үндэслэн салбарын хуулиа багцаар нь шинэчлэх ажлыг БОАЖЯ 2008 оноос хойш хийсэн. Цаашлаад оршин суугаа газар нутгийнхаа байгаль орчныг хариуцан хамгаалдаг, байгаль орчныхоо нөөцийг ашиглаж, эзэмшдэг, ажлын байр бий болгож, орлогын нэмэгдэл эх үүсвэрийг ардиргэд хүртэх зарчимд шилжүүлжээ. Мөн энэ багц хуулиар байгаль орчинд бохирдол доройтол үүсэхэд хариуцах тодорхой эзэнтэй буюу төр, орон нутгийн засаг дарга нар сүйтгэгчидтэй хариуцлага тооцох механизм бүрдсэн гэж мэргэжлийн хүмүүс үнэлж байна.

Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчныг сууриар нь шинэчилсэн нь хөгжлийн гараан дээр байгаа Монгол орны хувьд байгалийн баялгаа зөв хуваарилах, иргэд эрх тэгш боломж хүртэх, ирээдүй хойч үеийнхний амьдралын баталгааг хангахад чухал үүрэгтэй байх нь дамжаагүй.

Шинэ Засгийн газар дэлхийн хөгжлийн шинэ хандлагатай хөл нийлүүлэн алхаж, хөгжлийн галт тэргэнд амжиж сууна гэж найдъя. ■

И.ОТГОН

Төрийн ордноос ногоон эдийн засаг, ногоон хөгжил, ногоон бодлоготой холбоотой дуу хоолой тодорхой хэмжээгээр дуулдаж байхаар болсон нь энэ оны сонгуулийн онцлог байсан гэж хэлж болно. Учир нь, ИЗНН нэгдэж чадсан нь хууль тогтоох дээд байгууллагад “ногоон” өнгө нэмэв. МҮХАҮТ-ын гэдгээрээ олонд танигдсан С.Дэмбэрэл “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих” үндэсний хөтөлбөр хүртэл боловсруулсан нэгэн. Тэрбээр “улс төрд орж байж л би хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой юм байна. Гаднаас нь мянга хашгичаад нэмэр алга” гэж хэлж байсан удаатай. Түүний улс төрд орох сонголт нь мэргэн байлаа. Түүнчлэн “Сонгууль-2012”-д улс төрийн намууд ногоон гэдэг үгийг түлхүү хэрэглэсэн. Тэр дотор ИЗНН “Амьдрал” мөрийн хөтөлбөртэй оролцсон. Тухайлбал, УИХ-ын гишүүн, ИЗНН-ын дарга С.Оюун “Хүний хөгжлийн сан гэдэг шиг уул уурхайгаас орж байгаа тодорхой мөнгийг Байгаль орчны нөхөн сэргээх санд бүрдүүлнэ” гэж ярьж байсан. С.Дэмбэрэл, С.Оюун нар ногоон бодлого, ногоон сэтгэхүйн талаар ангийнхаа 74 андад учирлаж ойлгуулж, ногоон хөгжлийн үрийг

НОГООН ӨСӨЛТ

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ли Мён Бак номыг уншаад миний сэтгэл их хөдөлж билээ. Хар багаасаа бүр нялхаасаа үгээгүй ядуугийн зовлонг туулж, үүрийн жингээс үдшийн бүрий болтол ажиллаж, хоногт дөрвөн цаг унтаж ирсэн түүний амьдралын түүх өрөвдмөөр бас бахархмаар.

Б.БЭХЭЭ

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ли Мён Бак номыг уншаад миний сэтгэл их хөдөлж билээ. Хар багаасаа бүр нялхаасаа үгээгүй ядуугийн зовлонг туулж, үүрийн жингээс үдшийн бүрий болтол ажиллаж, хоногт дөрвөн цаг унтаж ирсэн түүний амьдралын түүх өрөвдмөөр, бахархмаар. Тэрбээр “Би хааяа архи уухаараа их даадаг. Учир нь, багаасаа л идэх хоолгүй тул архины шаар идэж өссөн болохоор тэр л дээ” хэмээн номондоо дурссан байдаг. Ийм л хорвоогийн гашуун түүхтэй тэмцэж, өөрийгөө нээж чадсан хүн өнөөдөр улс орноо удирдаад явж байна.

Ли Мён Бак бол дэлхийд ногоон хөгжлийг бий болгохын төлөө тууштай тэмцэж буй “ногоон” Ерөнхийлөгч гэж хэлж болно. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, мөн хүний хүчин зүйлээс хамааран сүйрч буй эх дэлхийг хамгаалах хамгийн найдвартай арга бол ногоон хөгжил, шинэ хандлага гэдгийг тэрбээр сурталчлан таниулах, бодит амьдралд хэрэгжүүлэх их үйлсэд тэргүүлэн, уриалан яваа удирдагч аж. Тиймдээ ч тэрбээр Ерөнхийлөгчөөр сонгогдонгуут улс орныхоо ирээдүйн 60 жилийн туршид даган мөрдөх алсын харааг шинэчилж “Нүүрстөрөгч багатай ногоон

өсөлт” хэмээн тунхагласан билээ. “Жинхэнэ өөрчлөлт нь хүмүүсийн зан байдалд гарах өөрчлөлт, нүүрстөрөгчийг бага байлгах амьдралын хэв маягийг сонгосноор ирнэ. Үүний тулд боловсрол олгох, хэрэглэгчдийн заншлыг өөрчлөх, мөн олон нийтийн дунд сурталчлах хэрэгтэй” гэж Ли Мён Бак онцлон тэмдэглэжээ.

Ногоон өсөлтийг дэмжих Ерөнхийлөгчийн хороо 2009 онд байгуулагдсан. Тус хороо нийт 50 гишүүнтэй, үүнээс 14 нь сайдууд, 36 нь хувийн хэвшил болон бусад төлөөлөгчөөс бүрэлддэг байна. Хороог Ерөнхий сайд болон хувийн хэвшлээс нэр дэвшсэн дарга нар удирддаг. Харин 2008 онд Солонгос Улс “Зүүн Өмнөд Азийн Уур амьсгалын түншлэл”-ийг (EACP) хөгжиж буй орнуудад уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад туслах зорилготой байгуулсан. EACP бол БНСУ-ын хамтын ажиллагааны гол хөтөлбөр бөгөөд хөгжилтэй буюу хөгжиж буй орнуудыг холбох гүүр болох зорилготой. Тус улс энэхүү байгууллагаар дамжуулж хөгжиж буй орнуудтай уур амьсгалын өөрчлөлтийн бэрхшээлийн талаар туршлага, ноу-хау солилцохыг анхаарч байна.

Азидаа хөгжлөөрөө тэргүүлэгч энэ улс өөрөө ногоон ▶▶





▶ өнгөөр хучигдсан орон гэж хэлж болох ч төрөөс нь улам ногооруулах бодлогыг чанд баримтлан ажиллаж байна. Үүний тулд төр, засгийн гол шийдвэрийг ногоонд чиглүүлэх, тууштай хэрэгжүүлэх, ард иргэдийнхээ оюун санаанд нөлөөлөх талд багагүй арга хэмжээ авчээ. Тухайлбал, “Нүүрстөрөгч багатай ногоон өсөлт” хууль, Ногоон өсөлтийн үндэсний стратегийг баталсан байна. Өөрөөр хэлбэл, ногоон хөгжлийг бүтээн байгуулахын төлөө тууштэй эрс шийдэмгий тэмцэж чаддагийн жишээ болж байна. “Ногоон өсөлтийн үндэсний стратеги” нь гурван гол зорилго агуулжээ. Нэгдүгээрт, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, улс орныхоо эрчим хүчний хараат бус байдлыг бэхжүүлэх, хоёрдугаарт, ногоон технологийг хөгжүүлэх, гуравдугаарт, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, Солонгосын олон улс дахь нэр хүндийг өргөх юм.

Мөн “Ногоон өсөлтийн таван жилийн төлөвлөгөө”-г хэдийнэ боловсруулж хэрэгжүүлээд байгаа аж. Тус төлөвлөгөөний дагуу жилд ДНБ-ий хоёр орчим хувийг ногоон өсөлтөд ирэх таван жилийн турш хөрөнгө оруулахаар шийдвэрлэжээ. Том шийдвэр. Энэ нь НҮБ-аас улс орнуудын Засгийн газарт зөвлөсөн хэмжээнээс

“Дэлхийн ногоон өсөлт-2012”

Дэлхий дахинаа шинэ хөгжлийг бий болгоход чиглэсэн олон хурал, семинар болдог болжээ. Тэдгээрийн нэг нь өнгөрсөн тавдугаар сард Сөүл хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн ногоон өсөлт-2012” уулзалт юм. Олон улс орны төр болон хувийн хэвшлийн төлөөлөгчид цаг уурын өөрчлөлттэй хэрхэн тэмцэх, иргэдийн сэтгэлгээнд яаж ногоон сэтгэхүйг суулгах, ногоон төр, засаг, ногоон бодлого шийдвэр, ногоон сэтгүүл зүйн асуудлаар харилцан ярилцаж, туршлага хуваалцсан билээ. Тус уулзалтыг манай сэтгүүлч сурвалжилсан билээ. БНСУ-ын Ерөнхийлөгч Ли Мён Бак дээрх арга хэмжээг нээж үг хэлсэн. Тэрбээр “Ногоон өсөлтийг хангахад дэлхий даяараа нэгдэн хүчин зүтгэх хэрэгтэй ба мөр зэрэгцэн ажилласнаар бидний хүчин чармайлтыг улам илүү болгох хэрэгтэй байна. Ногоон өсөлт нь тогтвортой ногоон эдийн засгийг хангах үлгэр жишээ байх тул бид

даруй хоёр дахин их тоо аж. Түүнчлэн ногоон технологид хөрөнгө оруулж, цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг гаргахад ихээхэн анхаарал хандуулсны зэрэгцээ 10 гол ногоон технологийг нэрлэжээ. Үүнд, дахин цэнэглэдэг зай, LED, ногоон мэдээллийн технологи, өндөр үр ашигтай фотоволтайк камер, ногоон автомашин, ухаалаг сүлжээ, дэвшилт цөмийн эрчим, түлш, хүчилтөрөгчийг хадгалах, CCS технологи, ус зэрэг багтсан байна.

Солонгосын бизнесмэнүүд ногоон сэтгэлгээнд суралцсан бас ойлгодог. Тийм ч учраас алхам тутамдаа байгальд ээлтэй бизнес эрхлэхийн төлөө ажилладаг гэж хэлж болно. Тогтвортой хөгжил нь бизнесийн хамгийн том ашиг гэдгийг ухаарсан Солонгосын хувийн хэвшлийнхэн сүүлийн жилүүдэд ногоон хөрөнгө оруулалтын хэмжээг ихэд нэмэгдүүлж буй ажээ. Тухайлбал, Солонгосын 30-аад компани нийлээд 15.1 их наяд воныг ногоон салбарт хөрөнгө оруулсан байна. 2008 онд 2.4 их наяд вон, 2009 онд 5.4 их наяд вон, 2010 онд 7.3 их наяд вонын хөрөнгө оруулалт хийжээ. Мөн фотоволтайк болон салхины эрчим хүчний хөгжилд 40 их наяд вонын хөрөнгө оруулахаар төлөвлөөд байна. Энэ бол улс орон, ард иргэд, цаашлаад үр хүүхэд хойч ирээдүйн төлөө хийж буй буян ажээ.

өнөөдөр дэлхий даяар энэ зурвасыг дамжуулж байна” хэмээн уриалсан билээ.

Монгол Улс энэхүү чуулга уулзалтын сэдвүүдийн нэг болов. Сэргээгдэх эрчим хүчээр баян Монгол орны баялгийг хамтарч ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгальд ээлтэй эрчим хүчээр Азийн гэрэл цахилгааны эрэлтийг хангах боломжийн талаар ярьсан юм. Энэ бол өндөр технологи, нөгөө талдаа асар их хөрөнгө шаардсан ажил аж. Тиймээс Азийн эрчим хүчний сүлжээг бий болгож, хамтран ажилласнаар асуудлыг шийдэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Энэ хүрээнд Японы Софтбанк, Солонгосын КЕПКО, Монголын “Ньюком групп” хамтран Азийн эрчмийн супер сүлжээ санаачилгыг бий болгожээ. “Атомын станц ямархуу хор хөнөөлтэй байгааг бид бэлхнээ харсан. Одоо япончууд цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг ирээдүйн хөгжил гэдгээр харж, эргэлт буцалтгүй энэ зүг явахаар шийдсэн. ▶▶

► Монгол Улсаас цаашдаанар, салхины цэвэр эрчим хүчийг импортоор авах боломж байна. Үүний тулд эрх зүйн болоод бусад орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай” гэж Софтбанкны гүйцэтгэх захирал Масайоши Сон онцолсон. Тэрбээр Азийн эрчмийн супер сүлжээ илтгэл тавьж хэлэлцүүлэхдээ Монгол орны нар, салхины нөөцийн талаар дэлгэрэнгүй ярьсан нь төлөөлөгчдийн сонирхлыг ихэд татсан билээ. Монгол Улс дэлхий дахинаа зөвхөн уул уурхай бус газар дээрх байгальд ээлтэй баялгийн нөөцөөрөө ч дэлхийг татах болсны нэг жишээ нь энэ байлаа.

Аж үйлдвэржилтийн гурав дахь хувьсгал нь ногоон эдийн засаг буюу шинэ технологийн хөгжил байх ёстой талаар энэхүү хурлаар хэлэлцсэн юм. Өмнөх хоёр хувьсгал нь ажлын байр бий болгох, уул толгод нүхэлсэн хүнд дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэж байсан аж. Тэгвэл одоо байгальд ээлтэй байгалийн нөөц боломжийг ашиглаж шинэ

үеийн шинэ хөгжлийг цогцлоон байгуулах шаардлага зүй ёсоор тулгараад байгаа хэрэг. Хаана нар, салхи, усны нөөц арвин байна, тэнд нөхцөлийг бүрдүүлж хөгжлийг бүтээх. Ийм хөгжлийг бүтээн байгуулахад улс орны хөгжлийн түвшин, ялгаа, хил зааг тийм ч чухал биш болох гэнэ. Өөрөөр хэлбэл, нар, салхийг ашиглахад манайх өндөр хөгжилтэй, танайх буурай гэх өрсөлдөөнөөр бус түншлэлийн ажиллагаагаар хамтран харилцан ашигтай ажиллах шаардлага бий болж буйг ойлгох ёстой ажээ.

Ногоон эдийн засаг бол ажлын байр олноор бий болгоно. Байгаль орчин, цаг уурт эерэг нөлөө үзүүлнэ, тогтвортой хөгжлийг бий болгоно. Энэхүү мэссэжийг олон нийтэд ирэх таван жилд сайтар сурталчилж ойлгуулахад улс орны Засгийн газрууд анхаарч ажиллах ёстой гэсэн зөвлөмжийг “Дэлхийн эдийн засгийн өсөлт-2012” хурлаас гаргасан юм.

Бидний өмнөх нэг хувь заяа

БНСУ-ын Ерөнхийлөгчийн “Дэлхийн ногоон өсөлт-2012” хуралд дээр хэлсэн үгийг товчлон хүргэж байна.

Өнөөдөр бид өөрсдийн зорилгоо нэгтгэснээр хэрхэн олон нийтийн засаглалыг бий болгон бэхжүүлэх талаар хэлэлцэхээр хуран чуулж байна. 2008 онд БНСУ нь Засгийн газар байгуулагдсаны 60 жилийн ойгоо тэмдэглэх үеэр нүүрсөрөгч бага ялгаруулах ногоон хөдөлгөөнийг үндэснийхээ шинэ алсын хараагаар тодруулсан билээ.

Дэлхий дахиныг хамарсан эдийн засгийн хямрал болон тодорхойгүй нөхцөл байдал дунд Солонгос улс нь нэлээд чухал өөрчлөлтүүдийг өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хийж тодорхой амжилтад хүрлээ. Үүнд хүлэмжийн хийг бууруулах таван жилийн хугацаатай техник эдийн засгийн төлөвлөгөө боловсруулахын зэрэгцээ ногоон өсөлтийг хангах хууль тогтоомж гарган ногоон байгууламж, ухаалаг сүлжээ байгуулах талаар хууль батлан гаргасан. Саяхан манай үндэсний чуулганаас Хүлэмжийн хийг бууруулах худалдааны талаар хууль тогтоомж гаргаж, намуудын зүгээс санал нэгтгэйгээр батлуулсан билээ. Ийнхүү бид ногоон өсөлтийг дэмжих алсын хараагаа бодитоор хэрэгжүүлэхэд тал талын арга хэмжээ авч байна. Улмаар Солонгос улс нь ДНБ-ий хоёр хувийг ногоон салбарт зориулахаар шийдвэрлэсэн. Мөн дээрх зорилтуудыг амьдралд бодитой хэрэгжүүлснээр ажлын байр олноор нэмэгдэснийг тэмдэглэхэд таатай байна.

Цаг уурын нөлөөнөөс үүдэн усны эх үүсвэр хомсдох аюул нүүрлээд байгаатай холбогдуулан дөрвөн голыг сэргээх төсөл хэрэгжүүлсэн байгаа. Энэ нь ган гачиг, үер тохиоход бэлтгэл хангасан төдийгүй цаашид ч туйлын үнэ цэнэтэй усны нөөцөө ухаалгаар зохицуулах арга хэмжээ авч, цаг уурын өөрчлөлтийг даван туулахад стратегийн ач холбогдол бүхий загвар хэмээн шинжээч нарын зүгээс өндрөөр үнэлсэн. Үүнээс гадна эдгээр нөхөн сэргээсэн голын дундуур 18,000 км дугуйн зам бариллаа.

Бид хэдийгээр хүнд хүчир бэрхшээлтэй тулгарч



байгаа боловч бидний өмнө дуусашгүй боломж байна. Бидний хийсэн дэвшил бол зөвхөн эхлэл төдий. Миний зүгээс улам илүү ажиллаж, улам ихийг хийхийг, зорихыг уриалмаар байна. Нэн ялангуяа эдийн засгийн өсөлт болон хүлэмжийн хийг бууруулах зорилтоо зэрэг хангах хэрэгтэй байна. Тиймээс аж үйлдвэрийн гуравдагч хувьсгал болох шинэчлэлийг үргэлжлүүлэх ёстой. Ногоон өсөлтийг хангахад дэлхий даяараа нэгдэн хүчин зүтгэх хэрэгтэй ба мөр зэрэгцэн ажилласнаар бидний хүчин чармайлтыг улам илүү болгох хэрэгтэй байна. Өнөөдөр энэ зорилго зөвхөн бидний хүрэнээс хальж өнцөг булан бүрээс төлөөлөгчид энэ асуудлаар санал нэгдэн хүрэлцэн ирснийг харахад туйлын таатай байна. Ногоон өсөлт нь тогтвортой ногоон эдийн засгийг хангах үлгэр жишээ байх тул бид өнөөдөр дэлхий даяар энэ зурвасыг дамжуулж байна.

Мөн БНСУ нь 200 сая долларын хөрөнгийг Зүүн Азийн санд ногоон шинэчлэлийг дэмжих ажилд зориулан босгохоор шийдвэрлэж байгаагаа хэлэхэд таатай байна.

Цаг уурын өөрчлөлт нь нийт хүн төрөлхтний өмнө тулгарч буй асуудал. Үүнийг зүй зохистой шийдвэрлэхэд бид хаа хүрэх тухайгаа нэгдсэн ойлголттой байх ёстой. Энэ ойлголт нь дэлхийн засаглалын үндэс суурь болох ба бидний өмнө байгаа нэг хувь заяа. Энэ бол дуусашгүй аялал ба хүн төрөлхтөн байсан цагт ногоон өсөлт үргэлжлүүлсээр байх ёстой нэгэн аялал байх болно. ■

Нүүдэлчид нарны эрчим хүчийг ашиглах болсон нь гайхамшигтай



КАНДЕЮМКЕЛЛА /ЮНИДО-гийн ерөнхий захирал/:

“Дэлхийн ногоон өсөлт-2012” хурлын үеэр манай сэтгүүлчид зарим төлөөлөгчийн сэтгэгдлийг сонирхсон билээ.

-Ногоон эдийн засаг гэж юу вэ?

-Ногоон эдийн засгийг энгийнээр тайлбарлах юм бол эдийн засгийн өсөлт, ажлын байрыг байгаль орчноо сүйтгэхгүйгээр бий болгохыг хэлнэ. Энэ нь хөгжиж байгаа орнуудад ихээхэн давуу талтай. Өөрөөр хэлбэл, экологийн тогтолцоонд сөргөөр нөлөөлөхгүйгээр өсөлтөд хүрэхийг хэлнэ. Монгол Улсын жишээн дээр ярихад, эдийн засгийн өсөлт, аж үйлдвэржилтийг байгальд ээлтэйгээр, элдэв бохирдол багатайгаар хөгжүүлэх хэрэгтэй. Танай улсын хувьд Солонгос болон бусад оронтой хамтарч ажиллах, түншлэх боломж нээлттэй байна. Иймд экологийн тогтолцоогоо сүйтгэхгүйгээр үйлдвэр барих боломжтой.

Дашрамд дурдахад, би Монгол Улсаар бахархаж байна. Энэхүү чуулга уулзалтын хамгийн шилдэг илтгэлүүдийн нэг нь Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглан Азийн орнуудыг эрчим хүчээр хангах тухай төсөл байлаа. Тус төсөл танай орныг баяжуулна. Хэрвээ энэ төсөл хэрэгжих юм бол Монгол Улс Солонгос, Японыг эрчим хүчээр хангана. Түүнчлэн танай орон байгаль орчинд халгүй цэвэр эрчим хүчний хангалттай нөөцтэй болно.

-Манай улс ногоон эдийн засгийг хэрхэн хөгжүүлж болох вэ?

-Ногоон өсөлт, ногоон эдийн засгийн ойлголтыг олон нийтэд илүү сайн хүргэж, сурталчлах хэрэгтэй. Хэрвээ олон нийт энэ ухагдахууны талаар эерэг зөв ойлголттой болж, хүний эрүүл мэндэд ямар ашиг тустайг мэдэх юм бол бүгд дэмждэг болно. Монголд надад анзаарагдсан нэг зүйл байна. Тэр нь танай улсын Засгийн газрын холбогдох хүмүүс ногоон эдийн засгийн концепцыг дэмждэг юм билээ. Тэгэхээр хөгжих боломж бий гэсэн үг. Хамгийн гол нь амьдралд бодитой болгоход л анхаарах ёстой. Танай оронд давуу талууд бий. Тэр нь нар, салхи, газар нутаг. Хөдөө орон нутагт нарны панель суурилуулсныг би харсан. Нүүдэлчид гар утсаа цэнэглэх, хоол ундаа хийхдээ нарны эрчим хүчийг ашиглах болсон нь гайхамшигтай.

-Уул уурхайн салбар Монголд эрчимтэй хөгжиж байгаа. Үүнтэй холбоотой Та юу хэлэх вэ?

-Экологийн тогтолцоогоо сүйтгэж болохгүй. Үүнд л төрөөс гол анхаарлаа хандуулах ёстой. Уул уурхайд ногоон, тогтвортой стандартыг зориулж гаргах хэрэгтэй. Мөн уул уурхайгаас олох ашиг орлого нь Монголыг Азид сэргээгдэх эрчим хүчээр нэгдүгээрт орох орон болгох боломжтой. Энэ боломжийг зөв ашиглаасай. Уул уурхайн баялаг бол нэг л өдөр дуусна. Харин сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хэзээ ч дуусашгүй баялаг юм.



АЛИ М.АЗИЗ,
/Йеменийн Эрчим хүчний яамны Төлөвлөлт, мэдээлийн хэлтсийн орлогч захирал/:

-Хөгжиж буй болон хөгжилтэй орнуудын томоохон ялгаа бол технологи, дотоодын нийт бүтээгдэхүүний зардал. Хөгжиж буй орнуудын ДНБ-ий нэг хүнд ногдох хувь бага байдаг. Иймд хөгжилтэй орны дэмжлэггүйгээр ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд хэцүү. Энэ тухай Киотогийн

протоколд “Хөгжиж буй орныг хэрхэн дэмжих вэ, технологи дамжуулах вэ” гэсэн санаа байдаг. Дэлхий нийтийг хамарсан дулаарал хөгжилтэй, хөгжингүй орнууд бүгдийг хамарна. Тус чуулга уулзалтын хүргэх гэсэн гол санааны нэг нь энэ юм.



ЭМИЛИА ХАРАХАП /Индонезийн Хөдөө аж ахуйн яамны Байгаль орчны дэд сайд/:

-Ногоон өсөлт нь байгаль орчноо анхааралдаа авч, ашиглалт, хамгаалалт хоёрын тэнцвэрийг олно гэсэн үг. Бид бусад улс орноос суралцаж болно, гэхдээ эцсийн эцэст тухайн улс орны хүчин чадлаас хамаарна.

Манайх Ногоон хөгжлийн зохицуулалтын тухай хуулийг шинээр гаргасан. Харин

нэвтрүүлэх талын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа. Индонези нь уудам газар нутагтай, том орон. Засгийн газрын зүгээс орон нутагтай харилцаа холбоогоо сайн тогтоож байж нэгдсэн ойлголтод хүрнэ. Энэ ажлыг алхам алхмаар хийнэ. ■



ЭХ ОРОНЧ УС

Хар ус харамладаггүй гэх ойлголттой монголчууд бид дусал усыг ч чандмань эрдэнэ мэт хайрлах цаг нэгэнт болжээ.

ЭЗОРИГТ

Ус хэдийгээр “Эх орныхоо төлөө зүтгэе” гэж хэлж чадахгүй ч бид Монгол Улсынхаа хөгжлийн төлөө ус гэгч чандмань эрдэнийг ашиглаж болох. Гэхдээ яаж?

Ус “уудаг” уул уурхай

Хүсэл, хясал хосолдог нь хорвоогийн жам гэлтэй. Нар, элс, заг гурваас өөр хараа баясгах зүйлгүй говийн хэвлийд шунал хөдөлгөм их баялаг нуугдана. Тэр их баялгийн эхнээс нь бид дэлхий нийттэй хуваан ашиглахаар их говийн хэвлийг онгилоод эхэлсэн. Гэхдээ говьд ус ховор. Усгүйгээр говийн тэр их баялгийг хэрхэн ашиглаж чадах билээ. Өнөөдөр уул уурхайн компаниуд нэг шоо метр усанд 150-хан төгрөг төлдөг аж. Гэтэл алт олборлохын тулд нэг секундэд 500 литр ус зарцуулдаг гэсэн судалгаа бий. Эрчим хүчний газрын Сэргээгдэх эрчим хүчний

хэлтсийн дарга Ч.Батбаяр энэ талаар “Оюутолгой, Тавантолгой гээд нөөцөөрөө дэлхийд гайхагдаад байгаа томоохон ордыг ашиглаж эдийн засгаа дэмжих нь зөв. Гэхдээ бид тэр уурхай хэр зэрэг өргөжих вэ гэдгийг зөвхөн мөнгөн дүнгийн ашгаар бус, усныхаа нөөц хэмжээнд тохируулах хэрэгтэй. Дэлхий нийтэд ч уул уурхайн салбар усныхаа нөөцөд тулгуурлан үйл ажиллагаагаа төлөвлөдөг. Тиймээс энэ тогтолцоог манай уул уурхайн салбарт нэвтрүүлэх нь чухал” гэв. Тэгвэл энэ талаар холбогдох албаны хүмүүс доорх хариултыг өгсөн юм.

Б.Чулуун /МУИС-ийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга/:

“Хож бас дахин хож” энэ бол зах зээлийн дүрэм. Гэхдээ бид аль аль талдаа хожоотой байх хэрэгтэй. Эдийн засгийн хувьд ч байгаль экологийн тухайд ч. Үүний

тулд усны нөөц, ашиглалт гээд бүх талд нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй байна. Өнөөдөр усыг байгаль экологийн тухайд л авч үзээд яриад байдаг. Гэвч ус нь өөрөө байгаль орчны болоод эдийн засгийн давхар хамааралтай. Тиймээс бид олон талаас нь харах зайлшгүй шаардлагатай байна.

З.Батбаяр /Засгийн газрын хэргэжүүлэгч агентлаг Усны газрын орлогч дарга/:

–Манайх 2020 он гэхэд энэ олон уурхайг усаар хангах боломжгүй болж магадгүй. Учир нь, манайд нэг хүнд ногдох усны нөөц хангайн бүсэд дэлхийн дунджаас 4-5 дахин их. Говийн бүсэд 10 дахин бага байна. Тиймээс бид усны нөөцийг судлахын зэрэгцээ усыг ашиглах өөр бусад бололцооны талаар ярих хэрэгтэй. Тухайлбал, усыг шилжүүлэн ашиглах боломжийн талаар гэдэг ч юм уу. Мөн ▶

► усны үнийн тухайд бид өөр өнцгөөс харах цаг нь болсон. Ус хаана их хэрэглэж байна тэр газарт өндөр төлбөр тогтоож болно. Уул уурхайн хувьд цаг хугацааны нийт зарлагын ердөө нэг хувийг л ус ашигласан төлбөрт өгөх нь аль аль талдаа боломжтой.

Д.Бэхбаяр/“Ногоон өсөлт” ТББ-ын гүйцэтгэх захирал, “Mongolian Economy” сэтгүүлийн эрхлэгч:

-Усны асуудал гэхээр зарим хүмүүс нэг хүнд ногдох ДНБ-ийг нэмэгдүүлчихээд дараа нь усыг ярьж гэдэг. Гэхдээ усны асуудал өдгөө дэлхийн олон орны төрийн бодлогод нь тусгалаа олсон байгаа. Мөн манай улсын хувьд ч ус бол тулгамдсан асуудал. Тиймээс усыг хэрхэн зөв зүйтэй ашиглах, эдийн засгаа хэрхэн дэмжих талаар ярих нь зөв юм. Гэхдээ бид яаж гэдгээ мэдэх хэрэгтэй. Тухайлбал, иргэдийн дунд усны үнэ цэнийг мэдрүүлэх нь нэн тэргүүний хийх ажил байх болов уугэжбихувьдаа бодож байна. Мөн “Эх оронч” усыг бий болгох хэрэгтэй байна. Өнөөдөр манай орны нийт усны нөөцийн 5.7 хувийг гадаргын ус эзэлдэг. Үүний 60 гаруй хувь нь гадагшаа урсчихдаг. Энэ байдлыг бид өөрчилж өөрийн оронд ашиглах хэрэгтэй. Үүний тулд “Эх оронч” бус гол мөрөн дээр өндөр хүчин чадлын усан цахилгаан станц барьж, үндэсний аюулгүй байдлаа бататгахын зэрэгцээ эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болох цаг болсон.

Ч.Батбаяр /Эрчим хүчний газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга/:

-Гадагш урсдаг гадаргын усыг ашиглах талаар эртнээс ярьж эхэлсэн. Үүний тулд Монгол орны хойд хэсгээр усан цахилгаан станц барих боломжтой. Гэхдээ манайд эрчим хүчний үнэ харьцангуй хямд байгаа учраас гаднын хөрөнгө оруулагчид үнэ мөнгөн дээр тохирч чаддаггүй юм. Тиймээс үнийн тал дээр анхаарах цаг болсон. Ер нь ус гэдэг манай орны хувьд байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний томоохон эх үүсвэрийн нэг мөн. Энэ нь тогтвортой хөгжлийн нэг тулгуур юм гэлээ.

Борооны ус ч “үнэтэй”

Бороо зөөлөн шиврэх, цас сэмээрхэн хаялахад дургүй хүн гэж хэн байх билээ. Бид бүгд л байгалийн энэ үзэгдлээс таашаал авч өөр өөрийнхөөрөө мэдэрдэг. Энэ бол нэг талаар үнэ цэнэ. Гэхдээ нөгөө талаар эдийн засгийн хувьд цас, борооны ус үнэ, цэнэтэй аж. Тухайлбал, гаднын олон оронд талбайн цас, борооны усыг хуримтлуулахын тулд траншей, далан, усан сан байгуулах аргыг өргөнөөр ашигладаг байна. Өнөөдөр манайхаас өөр нойлдоо хүртэл ундны усаа литр литрээр нь урсгадаг орон ховор. Харин гаднын орнуудад дээр дурдсан аргаар хураасан усыг энэ мэт зүйлд авч ашигладаг байна. Энэ нь дам утгаараа эдийн засгийн асар том хэмнэлт болж, үргүй зардлыг бууруулдаг аж. Тиймээс хар ус харамладаггүй гэх ойлголттой монголчууд бид дусал усыг ч чандмань эрдэнэ мэт хайрлах цаг нэгэнт болжээ. Харин усанд хайр зарлаж, хоосон ам гарахаасаа өмнө бид хэд хэдэн чухал асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулах цаг болсоныг “Mongolian Economy” сэтгүүлийн дэргэдэх “Ногоон өсөлт” ТББ-аас уриалж байна. Тухайлбал, усны нөөцийн нэгдсэн менежмент зохицуулалт үгүйлэгдэж буйг онцлон тэмдэглэж байна. Усны нөөцийн нэгдсэн менежмент гэдэг нь нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжил, хүний амьдралын сайн сайхныг дээд зэргээр хангах зорилгод усны нөөц баялгийг хамгийн зохистойгоор, экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглах нэгдсэн зохицуулалт хийх үйл явц аж. Тиймээс энэ тал дээр анхаарах хэрэгтэй гэдгийг холбогдох хүмүүс хэлж байна.

Мөн усны үнийн зохицуулалт байхгүйгээс усны зохисгүй хэрэглээ их байна. Тиймээс усыг үнэтэй болгох шаардлага бий. Учир нь, үнэгүй зүйл үнэ цэнэгүй байдаг. Үүнтэй холбоотойгоор саарал усыг дахин ашиглах талаар бодлого боловсруулах нь чухлыг “Ногоон өсөлт” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүд болоод учир мэдэх хүмүүс учирлаж байгаа юм. Ингэж чадвал бид усны гамгүй хэрэглээг халж, үнийн хувьд ч зохицуулалт хийж болох юм.

Өнгөрсөн хугацаанд тогтвортой хөгжлийг бий болгох талаар бид багагүй ярьсан. Зарим нэг ажлын эхлэлийг ч тавьсан. Гэхдээ тогтвортой өсөлт

байх эсэх нь усны бүх талын нөөцийг хэрхэн ашиглахтай холбоотой байдаг аж. Ус бол урт хугацааны хөгжлийг хангах нөөц гэж энэ талын эрдэмтэн, мэрэгжилтнүүд онцлон тэмдэглэх нь бий. Тиймээс бидэнд усны талаар урт хугацааны бодлого байгаа юу, үгүй юу гэх асуултад хариулах хэрэгтэй юм. Түүнчлэн судлаачдын сануулсанаар усны нөөц жил ирэх тусам багасч байна. Үүнд, байгаль экологи, уур амьсгалын өөрчлөлт асар их нөлөө үзүүлж байгаа ч эцсийн дүндээ хүний буруутай үйл ажиллагаанаас хамааралтай болохыг онцолж байлаа. Нөгөө талаас дэлхийн усны хэрэглээ өдөр ирэх тусам өсөн нэмэгдэх болсон энэ үед хүн ам өсөхийн хэрээр усны нөөц тулгамдсан асуудал болж буй. Тиймээс хүн төрөлхтөн усны хэмнэлтэд шилжих шаардлагатай болохыг сануулж байгаа юм. Харин бид дэлхий нийтийн нэг хэсэг.

“Mongolian Economy” сэтгүүл ногоон эдийн засгийг хөгжүүлэх бодлогын үүднээс усны талаар хөндөн бичдэг. Тухайлбал, сэтгүүлийнхээ 2011 оны эхний дугаартаа усны асуудлыг цогцоор нь хөндөж “Ангамал дэлхийн цангамал Монгол болох гэж үү” гэсэн сэдвээр сэтгүүлээ таны гарт хүргэж байсан билээ. Тиймээс шинэ Засгийн газар эмхлэгдэж байгаа энэ үед усны талаар дахин хөндөн бичиж байгаа нь учиртай юм. Дэлхий нийт ногоон өнгөнд хайр зарлаад байгаа энэ үед бид ч гэсэн ялгаагүй ногоон өнгөөр өөрсдийгөө чимэх хэрэгтэй. Харин ногоон хөгжлийн хамгийн чухал асуудал бол ус юм. Түүнчлэн дэлхий дахинаа усыг улс орны тогтвортой хөгжлийг тэтгэгч гэдгийг хүлээн зөвшөөрөөд байгаа. Тиймээс шинэ Засгийн газар энэ тал дээр анхаарлаа хандуулж ажиллана гэдэгт найдаж байна. ■



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ РҮҮ ХҮРЭХ ГҮҮР

Өдгөө хавсарсан технологийг дэлхий дахинаа уламжлалт аргаас сэргээгдэх эрчим хүч рүү хүрэх гүүр гэж үзээд байгаа юм. Харин сэргээгдэх эрчим хүч бол ногоон хөгжлийн тулах багана нь аж.


Бид нүүрсэнд хайр зарласан ч Бутаг үзэн яддаг. Арга ч үгүй биз нүүрсний ачаар манай улсын эдийн засаг өсч өндийн олон улс дахь нэр хүнд өссөн юм чинь. Харин бид утаанд зүрх сэтгэлийнхээ угаас дургүй. Гэхдээ л улаанбаатарчууд архаг бронхит, ургийн гаж төрөлт гээд утаатай холбоотой элдвийн өвчинд дарлуулсан ч нүүрсээ шатааж дулаацдаг хэвээрээ. Дэлхий нийт ч ялгаагүй нүүрсний утаанд дургүй. Тиймээс энэ тал дээр ихээхэн анхаарал хандуулж ажилладаг. Гэсэн хэдий ч нүүрс түлэхээ л багасгахгүй бол утааны асуудал байсаар байх болно гэдэг нь нэгэнт тодорхой болсон. Гэтэл дэлхий даяар нийт эрчим хүчний 80 гаруй

хувийг уламжлалт арга буюу нүүрс шатаах замаар гаргаж авдаг. Тиймээс нүүрснээс учиргүй татгалзах аргагүй. Гэхдээ нүүрсний хэрэглээг багасгах боломж бий. Үүнийг дэлхий дахинаа хавсарсан технологи гэж нэрлэдэг аж. Одоогоор уг технологи өргөн тархаагүй ч амжилттай хэрэгжиж байгаа юм. Тухайлбал, нарны болон уламжлалт аргыг хослуулсан технологи нь дэлхий нийтэд нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд буй. Одоогоор Марокко улс хамгийн том нарны эрчим хүчний панельтай хавсарсан систем ашигладаг байна. Нарны эрчим хүчний үйлдвэрлэлээс 30МВт-ыг, үлдсэнийг нь байгалийн хийнээс гаргаж авдаг гэнэ. Нарны туяа хүлээн авах гадаргуугын нийт талбай нь 260,000 ам.метр. Харин дараагийн

томоохон хавсарсан технологи Алжир улсад байдаг гэнэ. Ажиллах зарчмын хувьд бол дээрхтэй адилхан нарны эрчим хүчний панельтай хавсарсан систем аж. Харин нарны туяа хүлээн авах гадаргуугийн нийт талбай нь 250,000 ам.метр.


“Ньюком” тэргүүтэй байгууллагууд хамтран зохион байгуусан “Монголын сэргээгдэх эрчим хүч-2012” хурлын үеэр хавсарсан технологийн тал дээр тэргүүлэгч компани болох “Aben-гоа” компанийн Олон улсын бизнес хөгжлийн албаны дарга Жулиан Лопез Гарридо илтгэл тавьж, энэ талын технологийг монголчуудад танилцуулсан юм. Тэрбээр “Хавсарсан технологийг эдийн засгийн хувьд өсөлттэй байгаа оронд хийх нь тохиромжтой. Учир нь, эдийн засгийн өсөлтийг дагаад хөгжил яригддаг. Харин хөгжлийг өнөөдөр ногоон буюу байгальд ээлтэй болгох тал дээр дэлхий нийт анхаарч байна. Мөн хөгжлийн хамгийн чухал асуудал бол эрчим хүч юм. Тиймээс бид хамгийн түрүүнд эрчим хүчний салбараа ногоон болгох хэрэгтэй. Харин өнөөдөр Монголд эдийн засгийн өсөлтөөс аваад, сэргээгдэх эрчим хүчний асар их нөөц байна. Тиймээс хавсарсан технологийг хэрэгжүүлж болох хамгийн боломжит орон” гэж онцолсон юм. Тиймээс манай сэтгүүл энэ технологийг дэлгэрэнгүй танилцуулахыг зорилгоо.

Өдгөө хавсарсан технологийг дэлхий дахинаа уламжлалт аргаас сэргээгдэх эрчим хүч рүү хүрэх гүүр гэж үзээд байгаа юм. Харин сэргээгдэх эрчим хүч бол ногоон хөгжлийн тулах багана нь аж. ▶▶



Хавсарсан технологи гэж юу вэ

“Хавсарсан технологи гэдэг нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг уламжлалт нүүрсний технологитой хамтад нь хэрэглэснээр нүүрс хүчлийн хийг багасгах арга” гэсэн юм. Одоогоор нарны эрчим хүчийг уламжлалт технологитой хамтад нь хэрэглэх нь эдийн засгийн хувьд үр ашигтайд тооцогдоод байгаа аж. Тухайлбал, цахилгаан станцад нэг шинэ зуух барихын оронд хэд хэдэн нарны зай хураагуур суулгаж болох юм. Энэ нь нэг талаар овор хэмжээ бага, аюулгүй байдал болоод ашиглах хугацааны хувьд урт байдаг аж. Ажиллах энгийн зарчим нь өдрийн цагаар нарнаас гаргаж авсан дулааныг эрчим хүч болгон хувиргаад тусгай саванд хадгалах. Түүнийгээ гол станцаас гаргаж буй эрчим хүчтэй хамтад нь түгээх явдал аж. Жулиан Лопез Гарридо “Өмнө нь нүүрс шатаадаг байсан бол нарны зай хураагуурыг ашиглаж эрчим хүч гаргаж авна гэсэн үг. Гэхдээ олон мянган цахилгаан хэрэглэгчдийг хохироож болохгүй. Тиймээс станцын хэвийн үйл ажиллагаанд саад болохооргүй өргөтгөлийн ажлыг хийх шаардлагатай. Чухам энэ л шаардлагын улмаас бид нүүрснээс татгалзаж чадахгүй байгаа. Бүгд нүүрс хэрэглэхээ болино гэвэл дэлхий нийт тэрчигтээ амьгүй мэт болно. Харин нар болон нүүрсний хавсарсан технологийг ашигласнаар бага багаар нүүрснээс татгалзах боломжийг бүрдүүлэх юм. Суурилуулах буюу гол цахилгаан станцтайгаа холбох технологийн хувьд станцын үйл ажиллагаатай ямар ч хамааралгүйгээр хийж болдог гол учир нь оршиж байгаа юм. Гэхдээ газар бүрт өөр өөр суурилуулах технологи хэрэгтэй. Учир нь, тухайн орны байгаль цаг уурын байдал болон станцын хүчин чадал, насжилт гээд олон зүйлээс хамаарч тухайн технологи өөрчлөгдөж болно” гэв. Нар ба нүүрсний хавсарсан технологийг шинэ баригдах станцад хэрэглэж болохоос гадна, хуучин станцуудын угсралтыг өөрчлөлгүйгээр суурилуулж болдог байна. Эрчим хүч гаргаж авах ерөнхий зарчмыг доорх зургаас харна уу.



Технологийн давуу тал

-Тухайн нөхцөл байдалд тохируулсан хувилбар, угсралтыг хийх боломжтой

-Ашиглагдаж байгаа нүүрсний станцуудын хувьд энэ технологийг ашигласан ч хүчин чадлын хувьд буурахгүй

-Нүүрсний үнийн эрсдэлийг бууруулна

-Тухайн улсын эрчим хүчнээс хараат байдлыг бууруулна

-Хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгана

-Эх үүсвэрийн хувьд хязгааргүй гэх мэт олон давуу талтай аж.

Өнөөдөр дэлхий дээр байгаа эрчим хүчний уламжлалт болон бусад хэрэглээг хангах бүх төрлийн нөөц 10 тэрбум хүнийг л арай ядан тэжээж чадна гэдэг судалгаа бий. Тэгвэл 2050 он гэхэд дэлхийн хүн ам дээрх тооноос давах тэр үед бид яах вэ. Хариултын нэг нь сэргээгдэх эрчим хүч тэргүүтэй байгальд ээлтэй шавхагдашгүй нөөцүүдийг ашиглах. Харин Монгол оронд тэр бүх шавхагдашгүй нөөц байна. Тиймээс бидүгнөөцөөашиглахньчухал.Гэхдээ сэргээгдэх эрчим хүч хэт туйлширч барих нь өрөөсгөл хандаж болохгүй гэсэн сануулга бийг ч анзаарахад илүүдэхгүй болов уу. Тиймээс дээрх мэт хавсарсан технологийг авч

ашиглах нь эдийн засгийн болоод эрүүл мэндийн хувьд ашигтай юм. Энэ талын мэрэгжилтнүүдийн үзэж байгаагаар нар, нүүрсний хавсарсан технологийг Монголд ашиглах нь хамгийн тохиромжтой аж. Учир нь, манай говийн бүс нарны эрчим хүчний нөцөөр дэлхийд хоёрдугаарт ордог. Мөн нийт нутгаар жилийн 280-аас дээш хоногт нь нартай байдаг байна. Тиймээс эх үүсвэрийн хувьд бусад оронд байхгүй таатай нөхцөл бидэнд байгаа юм. Засгийн газрын зөвлөх “Энержи интернэшнл”-ийн тооцоолсноор Монгол Улс 2015 онд хамгийн багаар бодоход 744 МВт цахилгаан эрчим хүчний дутагдалд орохоор байгаа гэсэн байна. Өнөөдөр төвийн эрчим хүчний системд ажиллаж буй таван станц нийлээд 814 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг гээд бодохоор 744 МВт гэдэг аварга тоо. Энэ мэт эрчим хүчний дутагдалд орох хамгийн гол шалтгаан нь уул уурхайн эрчимтэй өсөлттэй холбоотой аж. Харин тэдгээр уурхай нар төөнөсөн шаргал говьд бүтээн байгуулалтаа хийж буй. Тиймээс бид шинээр барих цахилгаан станц мөн хуучнаа сэргээхдээ дээрх мэт хавсарсан технологийг ашиглах нь эдийн засгийн болоод байгаль экологийн хувьд ч ээлтэй юм. »

Нүүрсээр ажилладаг байгууллагад хавсарсан технологийг хэрэглэх нь

Энэ нь одоо ажиллаж буй байгууламжийн үйл ажиллагаанд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүйгээр сэргээгдэх эрчим хүчийг хямд төсөр аргаар

ашиглах боломж гэж үздэг байна. Гэхдээ үүний тулд байгууламжийн ашиглах хугацааг нарийн зохицуулалтын дор сунгах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байдаг гэнэ. Түүнчлэн уг хавсарсан технологи нь ногоон хөгжилд дөтлөх хялбар арга бөгөөд дутуу ашиглагдаж буй актив хөрөнгийг эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлдэг байна.

CSP+ нүүрсээр ажилладаг станц

Хямд сэргээгдэх түүхий эд нь түлшний тогтворгүй байдлын эрсдэлийг багасгана

- Фотовольтаик, дангаар ашиглагдах CSP технологи болон бусад сэргээгдэх эрчим хүчний үүсвэрүүдтэй харьцуулбал хямдаар цахилгаан үйлдвэрлэнэ
- Цахилгаан дамжуулалтад хийгдэх хөрөнгө оруулалтыг бууруулна
- Сэргээгдэх эрчим хүчний
- Нүүрсний зарцуулалтыг багасгана

Нүүрс ашигладаг байгууламжийн ашиглалтын хугацааг сунгана

- Нарийн зохицуулалтын доор техникийн ашиглалтын хугацааг сунгана
 - Нүүрсний зарцуулалтын хэсэгчилсэн орлуулалт
 - Нүүрсний зарцуулалтын бүрэн орлуулалт

Ашиглалтад буй байгууламжид болон сүлжээнд ямар нэгэн нөлөөгүй

- Сүлжээнд нөлөөлөлгүй
 - Нарны эрчмийн тогтворгүй байдлыг сулруулна
 - Ашиглагдаж буй шугам сүлжээ
- Байгууламжид үзүүлэх нөлөөлөлгүй
 - Чулуун нүүрсний шаталтын ашигт үйлийн коэффициент нь өөрчлөгдөхгүй
 - Технологийн суурилуулалтаас шалтгаалан их хэмжээний өөрчлөлт, техникийн сул зогсолт хийх шаардлагагүй

Шинээр барьж буй станцыг хавсарсан технологиор барих

Ингэснээр нийт гарган авч байгаа эрчим хүчний 30-40 хувийг магадгүй түүнээс дээш хувийг ч цэвэр эх үүсвэрээс гарган авч болох юм.

CSP+ нүүрсээр ажилладаг станц

Хямд сэргээгдэх түүхий эд нь түлшний тогтворгүй байдлын эрсдэлийг

- Бусад сэргээгдэх эрчим хүчний үүсвэрүүдтэй харьцуулбал хямдаар цахилгаан үйлдвэрлэнэ
- Нүүрсний зарцуулалтыг багасгана
- Хоёр байгууламжийг нэгтгэн суурилуулж байгаа тул дамжуулалтад хийх хөрөнгө оруулалт буурна

Хүчин чадлын хувьд зохицуулалт хийх боломжтой

- News installed capacity
- Сүлжээнд нөлөөлөлгүй
- Нарны эрчмийн тогтворгүй байдлыг сулруулна

Аливаа зах зээлд тохируулах боломжтой технологийн шийдэл

- Австрали гэр мэт цахилгаан эрчим хүчний зах зээлд туршлагатай орнуудын хувьд:
 - Сэргээгдэх эрчим хүчний зорилт
 - Диспетчерийн зохицуулалт шаардагдах хэрэглээ
 - Оргил ачаалал
- Цахилгаан эрчим хүчний зах зээлд хурдацтайгаар өсөж байгаа Энэтхэг, Хятад гэх мэт орнууд
 - цахилгаан хэрэглээ өндөр
 - Renewable component as an upside for producer operator society

БАЙГАЛЬ ӨӨРӨӨ ШҮҮГЧ НЬ

Дэлхий та бүхнийг танина, мэднэ. Хүмүүст Монгол гэж хэлэхэд очиж үзээгүй мөртлөө хаана байдгийг нь мэдэж байдаг. Энэ бол сайн эхлэл. Дэлхий дээр олонд танигдсан нэрийн хуудастай болж чадахгүй яваа олон улс байна. Монгол гэдэг нэр хэдийнэ брэнд болчихсон.



Б.ЭНХЦЭЦЭГ

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Талиб Рифай Монголд өнгөрсөн сарын сүүлээр дөрвөн өдрийн айлчлал хийсэн билээ. Тэрбээр айлчлалынхаа үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч болон БОАЖ-ын сайд тэргүүтэй аялал жуулчлалын салбарын холбогдох хүмүүстэй уулзсан. Түүнчлэн Цонжин Болдог, XIII зуун цогцолборт саатсан юм. Ажил амьдралын гараагаа архитектур мэргэжлээр эхэлж байсан ноён Талиб Иорданы Аялал жуулчлалын яамны сайд, томоохон компанийн захирал, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэд дарга гэх мэт хувийн хэвшил болон төр засгийн түвшинд олон салбарт ажиллаж байжээ. Манай сэтгүүл Талиб Рифайтай ярилцсанаа хүргэе.

-Таныг 140 гаруй орноор аялсан гэж сонссон. Тэгвэл Монголыг тэдгээр улстай харьцуулахад ямар сэтгэгдэл төрж байна вэ?

-Монгол Улс бусдаас өвөрмөц. Эцэс төгсгөлгүй үргэлжлэх ногоон хивс мэт ер бусын байгаль нь энэ улиралд хамгийн үзэсгэлэнтэй юм. Гэвч хаана ч байгалиас илүү чухал зүйл нь хүмүүс байдаг. Учир нь, улс болгон өөрийн гэсэн өвөрмөц байгалийн тогтоцтой. Монголчууд шиг хүмүүсийг дэлхийн хаанаас ч хайгаад олохгүй байх гэж бодож байна. Эелдэг нөхөрсөг, халуун дулаан уур амьсгалаар эх оронтойгоо холбогдсон байдаг нь яг л хүн байгаль хоёрын хоорон дахь төгс зохицол гэмээр. Гэвч би энд Монголыг илүү, дутуу гэж хэлэхдээ гол нь биш харин онцгой орон гэдгийг л тодотгох гэсэн хэрэг.

-Таны хувьд Монгол орны чухам юу нь дахин давтагдашгүй цорын ганц гэж хэлж чадах вэ?

-Хүн ард, соёл уламжлал гэж хариулна.

-Та Монголд ирэхээс өмнө Австралид гурван өдрийн айлчлал

хийсэн. Тэгвэл энэ хоёр орны хувьд ямар ижил төстэй талуудыг харж байна вэ?

-Би хувьдаа ганцхан ижил зүйл харсан. Соёл уламжлал, байгаль орчин бүгд өөр боловч уул уурхайд суурилсан эдийн засагтайгаараа энэ хоёр орон адилхан санагдлаа. Австрали, Монголын аль алиных нь хувьд уул уурхай хамгийн чухал салбар. Гэвч Австрали улсын хувьд уул уурхайд хэт найдаж болохгүй гэдгээ ухаарсан учир аялал жуулчлал болон бусад үйлчилгээний салбарын үйл ажиллагааг хөгжүүлэхээр чармайж байна. Монгол Улсыг ч гэсэн ирээдүйгээ хэтдээ ингэж хараасай гэж хүсч байна. Уул уурхайгаас олсон ашгаа бусад шинэлэг, өөр хэсгийн хөгжилд хөрөнгө оруулалт хэлбэрээр ашиглаж байгаа юм. Энэ нь тухайлбал аялал жуулчлал.

-Австрали тэргүүтэй орнуудтай харьцуулахад Монголын аялал жуулчлалд ямар давуу талууд бий гэж бодож байна?

-Энд гурван чухал давуу тал байна. Нэн түрүүнд Орос Хятад гэх хоёр том зах зээлийн дунд оршдог. Австрали, Европын зах зээл Хятадын жуулчдыг авахын тулд хоорондоо ширүүн өрсөлддөг. Монголын хувьд тэмцэлдээд байх ч шаардлага алга. Зүгээр л хилээ нээгээд өгөхөд л болно. Хоёр дахь давуу тал гэвэл аялал жуулчлал Монголын эдийн засаг нийгмийн түвшинд үр ашиг авчрах талтай. Монголд ажлын байр олноор нь бий болгох хэрэгтэй байна. Аялал жуулчлалын нэг давуу тал нь хүмүүст оршин байгаа газраа ажиллаж амьдрах боломжийг олгодог явдал юм. Монголын хувьд нүүр тулаад байгаа олон сорилтыг даван туулахад аялал жуулчлал хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Тийм учраас Аялал жуулчлалыг хөгжүүлэх нь энэ орны хувьд ихээхэн ач холбогдолтой юм. Гурав дахь том хүчин зүйл нь Монгол Улс Азийн зүрхэнд оршдогтой холбоотой. Азийн эдийн засаг тэсрэлттэй байгаагийн хажуугаар энэ тивийн аялал жуулчлал ч хамгийн

эрэлттэй зах зээл болоод байна. Та бүхэнд амттай хоол хийх бүх л орц найрлага нь байна.

-Монголын аялал жуулчлалын салбар улирлын чанартай. Тэгвэл энэхүү улирлын шинжтэй зах зээлийн нөөц боломжийг хэрхэн өргөтгөж болох вэ?

-Би нэг жишээ хэлье л дээ. Норвеги, Фяланд, Швед зэрэг улсад зочлох хамгийн таатай улирал нь нарны гэрэл бараг тусдаггүй гэж хэлж болох арванхоёр, нэгдүгээр сар байдаг. Цас их ордог учир хүйтэн. Гэвч эдгээр орны үзэсгэлэнт байгалийг харах гэж хүмүүс олноороо очдог.

Миний хувьд арванхоёр, нэгдүгээр сард гайхалтай дурсамж үлдээх онцгой адал явдлыг Монголд бий болгож болохгүй байх шалтгаан олж харахгүй байна. Улирлын чанартай аялал жуулчлал гэдэг бол тогтчихсон төөрөг биш. Өвлийн аялал жуулчлал зунаас дутахгүй хүчтэй соронз байж чадна.

-Монголд анх удаа ирж байгаагийн хувьд хотын гадна хийсэн богинохон аяллын талаарх сэтгэгдлээ хуваалцахгүй юу?

-Байгалийн гоо үзэсгэлэнд сэтгэл минь их хөдөллөө. Хагас цаг хүрэхгүй хугацаанд хотоос гарч онгон байгалийг мэдрэх боломжтой нь гайхал төрүүллээ. Энэ бол бас л дэлхийн хаана ч байхгүй боломж. Намайг гайхшруулсан бас нэг зүйл нь энэ орны цээж дүүрэн амьсгалах цэнгэг агаар. Эцэст нь хүн ард, морь малын хоорон дахь нандин харилцаа холбоо үнэхээр гайхалтай санагдлаа. Мөн аяллынхаа үеэр Монгол үндэстний наадмыг үзэж сонирхлоо. Бөх барилдаж, нум сум харваж морь унаад давхичихмаар тийм л сэтгэгдэл төрлөө.

-Өнөөдөр дэлхийн аялагчид аль зүгт ихээр тэмүүлж байна вэ?

-Дэлхийн хүмүүс өнөөдөр хаа сайгүй аялж, юм болгоныг үзэж туршлага хуримтлуулах болсон. 2012 оны эцэс гэхэд дэлхий дээрх нийт аялагчдын тоо нэг тэрбумд хүрэх төлөвтэй байна. Энэ нь зургаан хүний

► нэг нь аялж байна гэсэн үг. Дэлхий ихээхэн хөдөлгөөнд оршиж байна. Янз янзын газраар аялж үзэхийг зүгээр л хүний хэрэгцээ эсвэл хүний эрх гэж хүлээж авдаг болчихож. Тэд олон янзын зорилгоор аялдаг. Өнөөдрийг хүртэлх судалгаагаар, дэлхийн аялагчдын 52-55 хувь нь амралт зугаалгаар уул хад, далайн эрэг рүү явдаг гэж гарсан. Харин тэдний 20 хувь нь бизнесийн аялагч байдаг бол 25-30 хувь нь бусад төрлийн зорилгоор аялдаг байгаа юм. Айлд зочлох, эсвэл эмнэлгийн үйлчилгээ авах зэрэг нь бүгд зорилго ондоотой ч аялалд багтдаг. Тиймээс бүх дэлхий ертөнц аялалд нээлттэй болж ирж байна. Энэ дэлхий дээр хүрч болохгүй газар гэж үгүй болсон.

-Та Монголын соёл уламжлалыг цорын ганц онцлогт тооцож байсан. Тэгвэл манайд соёл уламжлалд суурилсан аялал жуулчлал хөгжүүлэх боломж хэр байх бол?

-Тийм. Гэвч миний хэлэх гэсэн санаа үүнээс ч өргөн цар хүрээтэй. Соёл уламжлал гэх ойлголт нь өргөн утгаараа байгаль орчин, амьтан ургамал, хүн ард мөн соёлын чухал хүчин зүйлүүд болох дуу хуур, уламжлал, хоол гээд цөмийг нь агуулдаг. Учир нь, энэ бүгд өнө удаан хугацаанд уламжлагдаж ирсэн соёлын салшгүй нэг хэсэг юм. Монголд бусдыг татах бас нэг онцлог байдаг нь "Монгол" гэсэн брэнд юм. Дэлхий та бүхнийг танина, мэднэ. Хүмүүст Монгол гэж хэлэхэд очиж үзээгүй мөртлөө хаана байдгийг нь мэдэж байдаг. Энэ бол сайн эхлэл. Дэлхий дээр олонд танигдсан нэрийн хуудастай болж чадахгүй яваа олон улс байна. Монгол гэдэг нэр хэдийнэ брэнд болчихсон.

-Та түрүүнд нь аялал жуулчлал уул уурхайн дараах хамгийн зөв сонголт байж болох тухай ярьсан. Энэ салбарын үр өгөөжийн талаар дурьдахгүй юу ?

-Аялал жуулчлал бусад салбарын өгч чаддаггүй орлогыг авчирдаг. Улаанбаатараас гараад явахад зам дагуу хүмүүс ямар нэг зүйл зараад зогсож байна. Аливаа гэр бүл аялал жуулчлалтай холбоотой

үйл ажиллагаанаас олсон мөнгөөр хангалттай амьдарч болдог. Дээрх олсон орлого томоохон бизнес гэхээсээ илүүтэй өрхийн амьдралд шууд хөрөнгө оруулалт болдогоороо онцлог. Энэ бол жирийн иргэдийн амьдралтай шууд холбогддог салбар. Таксины жолооч, сүү цагаан идээ, гар урлалын худалдаачин, байр түрээслэгч гээд тоолж барамгүй олон хүн энэ салбараас ашиг хүртдэг. Хүмүүсийн амьдралд шууд хэлбэрээр мөнгөн орлого бий болгодог салбар бол аялал жуулчлал.

Хүмүүст тэр дундаа залууст олон тооны ажлын байрыг бий болгодоогоороо ихээхэн ач холбогдолтой. Залуус ч аялал жуулчлалын салбараар ажлын гараагаа эхлэх сонирхол өндөртэй байдаг. Учир нь, хэцүү хүнд зүйл энэ салбарт харьцангуй бага. Дээр хэлсэнчлэн энэ салбар хүмүүст оршин байгаа газраа ажиллаж амьдрах боломжийг олгодог.

-Хэрэв Монгол Улсын аялал жуулчлал хөгжил эхлэл төдий яваа юм бол хаанаас эхэлж, юуг түрүүлж хийх нь зүйтэй вэ? Төрийн бодлого чиглэлд анхаарах уу эсвэл хувийн салбарынхан мэрийх үү?

-Мэдээж хэрэг төрийн бодлого чиглэл нэн түрүүнд явах ёстой. Монголд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэгдсэн стратеги, хэтийн төлөвлөлт байх хэрэгтэй. Улмаар Засгийн газраас сайн дэмжих хэрэгтэй. Харин хувийн салбарынхан дээрх бодлого чиглэлийг хамтран боловсруулж, өргөн барих хэрэгтэй. Стратеги, бодлого чиглэлгүйгээр хол явахгүй. Стратеги боловсруулсны дараа зорилго, зорилтуудаа тодорхойлж улмаар юуг яаж хиймээр байгаагаа тайлбарлах хэрэгтэй. Үүний дараа гурван чухал даалгаварыг эхлүүлэх шаардлагатай болно. Нэгдүгээрт; бүтээгдэхүүнээ хөгжүүлэх / дэд бүтцийг сайжруулах/ хоёрдугаарт; бүтээгдэхүүний хөгжил ба сурталчилгаа эцэст нь сургалт. Энэ гурван үйл ажиллагааг хамтад нь хэрэгжүүлэх ёстой. Бие биенээс нь салгаж, наана цаана нь оруулж болохгүй.

-Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын зүгээс Монголд ямар дэмжлэг үзүүлэх боломжтой вэ?

-Бид одоогоор зөвлөгөө өгөх замаар тусалж байгаа. Тухайлбал, би айлчлалынхаа үеэр Ерөнхийлөгчтэй уулзсан байгаа. Танай улсын Ерөнхийлөгч аялал жуулчлал Монгол Улсын хөгжилд томоохон ач холбогдолтой болох тал дээр надтай санал нэгдэж дэмжиж байгаагаа илэрхийлсэнд талархаж байгаа.

Бид улс төрийн замаар буюу эрх барих түвшинд аялал жуулчлалын хөгжилд тус нэмэр болохоор зорьж байна. Мөн техникийн түвшинд тусалж байгаа. Тухайлбал, одоогоор бид Монголын зарим арга хэмжээг /уралдаан, баяр наадам зэрэг/ онцлон зохион байгуулж, түүгээр дамжуулан Монголыг сурталчлахаар ярилцаж байна. Бидний тусламж дэмжлэгийн дундаас хамгийн чухал нь Монголд ирэх жилүүдэд баримтлах аялал жуулчлалын стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлж байгаа явдал юм. Бид үүнийг өөрсдийн мэргэжилтэн, зөвлөх болон хуримтлуулсан туршлага мэдлэгээрээ дамжуулан хийх болно.

-Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамгийн чухал нь юу вэ?

-Хамгийн чухал нь эко аялал жуулчлал аялж зугаалахыг илүү сонирхолтой болгох бус байгаль орчныг хамгаалахад чиглэх ёстой гэсэн үндсэн зарчмыг баримтлах хэрэгтэй. Хэрэв аялал жуулчлал хаа нэг тийшээ чигээ залбал тэр газар орон өөрөө шүүгч нь байж жуулчид ирсэн ирээгүй өнгө зүс орж л байх ёстой. Хэрэв үгүй аваас энэ аялал жуулчлал биш. Юу юунаас илүү чухал нь эко аялал жуулчлалын менежмент, олсон орлого нь эрүүл, таатай байгаль орчинг бүрдүүлэхэд чиглэгдэх юм.

-Та хэзээ дахин Монголд ирэх вэ?

-Ирэх жил эхнэр хүүхдээ дагуулаад ажлаар бус амралтаар ирж, Монголын үзэсгэлэнт байгаль, хүн ардтай илүү дотно танилцъя гэж бодож байна.■



2012 ОНЫ ДЭЛХИЙН “ГАЙХАМШГУУД”

Таны хүсэл сонирхлыг 2012 онд ямар газрууд урин дуудаж байна вэ. Америкийн National Geographic сувгаас эрхлэн гаргадаг “Traveler” буюу “Аялагч” сэтгүүлээс энэ жил дэлхийн хүмүүсийн анхаарлыг хамгийн их татаж буй 20 орныг нэрлэжээ. Тус 20 орноос манай сэтгүүл онцлох 10 орныг танилцуулж байна.

Б.цэцээ

Хөндөгдөөгүй Хөвсгөл /Монгол/

Онгон дагшин байгалийг мэдрэхийг хүсч байвал зорьсон газар чинь энд байна. Хөвсгөл нь Монгол Улсын 21 аймгийн хамгийн хойд хэсэгт Оросын их гүрний хил дээгүүр сүүдрээ унаган оршино. Мөн энэ нутаг далайн түвшнээс дээш 3000 гаруй метрийн өндөрт гүн ногоон, улбар шар өнгөөр гоёсон Сибирийн их тайгыг хуваалцан аж төрдөг. Нутгийн ард түмэн цасан

малгай өмссөн уулаас эхтэй гэгддэг хөндөшгүй гол нууруудыг хэзээ ч хөлддөггүй хэмээн ярилцдаг юм билээ.

Хөвсгөл нуураас салбарлах гол мөрнүүдэд тул загас, голын чоно гэгддэг аварга яргай загас бий. Тэдгээрийг барих хүсэлтэй олон тооны жуулчинд Хөвсгөл нутаг өврөө дэлгэнэ. Харин зарим аялагчид нутгийн цаатан хэмээх цаа буга маллаж, урцанд амьдардаг уугуул иргэдтэй уулзахаар монгол мориор аялдаг байна. ▶



► Эко-Гайхамшгийн орон / Панама/

Хоёр тивийг холбосон гүүр болох Панама улс төв цэгээсээ далай хүртэл хааш хаашаа ердөө л 82 км зайтай нь тус улсыг ямар жижигхэн болохыг харуулж байна. Гэвч төв Америкийн бүсэлхийг тойрон орших олон улсын худалдааны гинжин холбоо Панамын суваг нь 2014 он гэхэд нэг талдаа Номхон далай нөгөө талдаа Атланتيкийн далай руу чиглэсэн сувгуудаа тэлж дуусгахаар зэхэж байна. Тэр үед Панамын сувгаар 13,000 тоннын ачааны хөлөг онгоцоор тээвэрлэлт хийх боломжтой болох юм байна. Харин олон улсын худалдаачид тус колонийн нийслэлийг шил толь болсон орчин үеийн зочид буудлаар гоёсон байх ажээ. ►



▸ Африкийн догшин, ногоон зүрх /Вирунга Галт Уулс/

Энэ дэлхийн хаана ч Африкийн Вирунга галт уулс шиг бүтээлч бас сөнөөгч галт уул байхгүй биз ээ. Руанда, Уганда болон Конго улсын газар нутгийг дамнан орших найман цувраа энэхүү галт уул нь дэлхийн хамгийн идэвхтэй галт уулын бүсэд хамаарагдах авч уулын Горилла, Шимпанзе сармагчин, заан болон бусад зэрлэг амьтдын хоолны тогоо болдог нь нэн сонирхолтой. Тус гурван улсын илбийн мэт гоо үзэсгэлэн диваажингийн цэцэрлэг ба халуун там гэсэн хоёр дүртэй.



Дугуйчдын диваажин /Шинэ Зеланд/

Маоригийн домгоор энэ дэлхийг догшин тэмцэл бүтээсэн гэдэг. Шинэ Зеландын уугуул иргэдийн ярьдгаар бол эцэг тэнгэр, эх дэлхий уул ус, ой моддыг багтаах зай гаргахын тулд бие биенийхээ гараас тавьж, салан одсон гэдэг. Роторуагийн ойролцоо Маоригийн зүрхбуюу төв хэсэг нь эрдэс чулуулгаар хүрээлэгдсэн оргилуун усан сантай. Сэтгэл сэрдхийм газрын гадарга нь яг л балар эртний үе мэт буцлан хөөсөрч, даргин чичирч байхыг харахад өнө эртний домгийн тэмцэл өдийг хүртэл үргэлжилж буй мэт санагдана. Булаг оргилон, шавар буцалж хадан хавцлаас эхлэн явган хүний замаас хүртэл уур савсах агаад энэ бүхний ул мөр агаартай сүлэлдсэнийг хамар сэнгэнүүлэх хүхрээс мэдэж болох.



Энд адреналинд дурлагсад пуужингийн галзуу хурдыг мэдэрч, аварга хуванцар бөмбөгөөр уул толгодын дээрээс өнхөрөх дуртай. Харин байгаль дэлхийтэй илүү ойр, ухаалгаар цагийг өнгөрөөх нэг арга гэвэл дугуйгаар аялах юм. Халуун рашаан, мөсөн гол, чийглэг шигүү ой, галт уулуудаар хүрээлэгдсэн энэ улс нь Колорадогоос томгүй буюу 16 мянган км далайн эрэг бүхий газар нутагтай. Шинэ Зеланд нь бие махбодь, сэтгэл санааны хувьд аялал хийхэд төгс тохирсон газар гэгддэг.

Байшин улс /Маскока Онтарио/

Онтариогийн байшин улс Маскокагийн зүрхийг амьдруулж байдаг Торонтогийн цахилгаан станцаас машинаар явбал хоёр цагийн зайтай авч өнөөгийн ертөнцөөс асар хол. Зэрлэг онгон байгальтай энэ газар айлууд үе удам дамжин амьдарч иржээ. Тус газар нь дөрвөн мянга гаруй газар нутгийг эзлэн орших бөгөөд баруун талаас Алгонквин мужийг хүрээлэн, зүүн талаас Жиоржиан эргийн арлуудаар хүрээлэгдэнэ. Маскока нь 17 түүхэн дурсгалт хот суурин, тоолж барамгүй хүхрээ, гол мөрөн болон 14 мянга гаруй км үргэлжлэх эргийн шугамыг өөртөө багтаадаг билээ. ▸



▶ Эртний гоо үзэсгэлэн /Грек/

Өнгөрсөн оны зургаадугаар сард мөнх бусыг үзүүлсэн Патрик Лей Фермор нь Грекийн соёлд сэтгэл зүтгэлээ өгсөн нэгэн байсан билээ. Тэрбээр хэлэхдээ, Грекийг гүнзгий таньж мэдье гэвэл далайн эргийн амралтын газруудаас хол байх хэрэгтэй. Румели болон Мани уулсын хавцлаар явган аялсан Лей Фермор тус орны соёл уламжлал үзэсгэлэнт зэлүүд энэ газар л нуугдан оршдогийг олж тогтоожээ. Эцэст нь тэрбээр хэн хүн очоод байдаггүй өмнөд Палопонессийн нурамгар Кардамали тосгонд суурьшсан юм. “Энд хийгээд байх зүйл багатай тул аялал жуулчлалын өрөвдөлтэй золиос болохгүй гэдэгт найдаж байна” гэж Лей Фермор хэлж байжээ.

Түүний зөв байсан юм. Тус улсын зарим арлууд зохицуулалт муутай хөгжлийн хохирогч болсон бол зарим хадархаг нутгийн гүнд дур булаам гоо үзэсгэлэн хүний хөлөөс зайдуу нуугдсан хэвээр. Епируст мөөг түүж, Преспа мөрний дээгүүр ягаан өнгийн хотон шувууд нисэлдэхийг харж, цаг зогсоогч Метеорагийн хийдийн ном унших чимээг сонсох юутай гайхалтай.



Орчин цагийн Маяа ертөнц /Гуатамала/

Нэгэн цагт агуй Маяагийн хот, суурин байсан гэгддэг Чичен Ица /Мексик/, Тикал /Гуатамала/, Каракол /Белидце/, Копан /Гондурас/ хотын туурийг жил бүр тоолж баршгүй жуулчид зорьдог. Эндхийн пирамид, хүн хөшөөнүүдийг үзэхгүй өнгөрөхийн аргагүй. Ялангуяа ширэнгэн ойгоор далдлагдсан Тикал хот хамгийн сонин бөгөөд содон үзвэр. Маяагийн соёл иргэншил бүрмөсөн мөхөөгүй. Маяагийн оргил үе улиран одсон байж болох ч сая сая маяачууд болон тэдний соёл заншил Гуатамалагийн баруун өндөрлөг хэсэгт бат бэх оршин тогносоор байгааг харж болох юм.

Маяагийн өв соёлын дурсгалт газруудаас хамгийн сонирхол татам нь Чичикастенанго юм. Хүн амынх нь бараг 95 хувь нь уугуул иргэд гэж хэлж болох тус хот нь Гуатамалагаас засмал замаар гурван цаг явж хүрэх зайд байрлана.



Эргэж ирсэн хүү /Дрезден/

Саксоны хаан нийслэл хотоо өөрсдийн эд хөрөнгөөр “Элбийн Флоренц” шиг болгохоор зорьж байсан 1700-гаад оны тэртээ Дрезден нар шиг мандаж байлаа. Гэвч 1945 оны хоёрдугаар сард Их Британи болон Америкийн хоёр өдөр үргэлжилсэн бөмбөгдөлт Дрездений төвийг үнс болгож, хэдэн▶

▶ арван мянган хүнийг нөгөө ертөнцөд илгээсэн билээ. Бүтэн 70 жилийн дараа тус хотыг Герман улсын тэргүүлэх аялал жуулчлалын цэг болгохоор сэргээн засварласан байна. Хатагтайн сүм нэртэй түүхэн дурсгалыг Жеорж Бэр барокко хийцээр бул чулуу ашиглан дахин зохион бүтээжээ. Уг түүхэн дурсгал нь өнөөдөр дэлхийн хэмжээний томоохон музейн талыг өөртөө агуулдаг бөгөөд Албертиниумаас эхлэн хуучны уран зургийн сод бүтээлийн галлерей, эрүүл мэндийн музейг хүртэл эзэмшдэг ажээ.



Төгс зохицол /Исланд/

Пенинсулагийн балар эртний төрхийг бүрэнхий бүчин авлаа. Мөстлөгийн үеийн сүүлчийн ул мөр болох энэхүү Хойд Атлантикийн арал улс нь хутгаар сийчүүлсэн мэт хөндий, үлэмж хавцал, сүрлэг хадан хясаа, хар элсэн эрэг, аянга мэт буух хүрхрээ болон анир чимээ үгүй мөсөн голуудаар гоёсон орон. Саяхан дэлбэрсэн галт уулын нуранги хэн бүхэнд Исланд улсад байгалийн бүтээн байгуулалт дуусаагүй болохыг харуулна. Тус улс гоо төрхөө өөрчилсөөр байдаг нь исландчуудын хувьд хэзээ ч дуусаагүй нээлт.



Эдийн засгийн хямралыг гэтлэх гурван жилийн хугацаанд хэрэглэгчийн худалдан авах чадварыг евротой нягт уяснаар Исланд улсыг харьцангуй хямд өртөгтэй орон болгожээ. Мянга гаруй жил өөрөө өөртөө найдан амьдарч ирсэн тус улс дэлхий дээрх хамгийн хөгшин хэлүүдийн нэгээр харилцсаар байгаа орон билээ. Мөн цэвэр технологийг бүрнээ нэвтрүүлсэн орнуудын нэгэнд тооцогддог.

Испанийн уран бүтээлч эрэг /Коста Брава/

Усанд хөвөх шар, улаан, цагаан өнгөөр будсан завинууд газар дундын тэнгисийн аль ч эрэгт харьяалагдаж мэднэ. Урлагийн чиглэлээр дэлхийд этгээд хачинаараа гайхагдсан хүмүүсийн нэг Салвадор Дали нь Испанийн зүүн хойд хэсгийн Коста Брава буюу Каталоньягийн хэсэгт төрж өссөн аж. Нарны гэрлээр хөтлүүлсэн онгон дагшин үзэсгэлэнт төрх түүний хожмын аварга өндөг, хунгийн оргилуур, хайлж буй цаг гэх мэт сонирхолтой уран бүтээлийн эх ундрага байсан биз ээ.



Дундад зууны үеийн Жирона хотод жил бүр зохиогддог цэцгийн наадам уран сэтгэмжийг өдөөгч нэгэн сэдэл болдог байна. Сүм, дуганын шатаар цэцгэн гол урсаж, хотын гудамж талбай, чулуун ханыг дүүргэсэн олон гайхамшигт бүтээл хэн хүний гайхширлыг бардаг ажээ. Загасны тосгон Калалле ди Палафругелийн эрэг дагасан зоогийн газар, байшин нь тун ч өвөрмөц. ■

ЁС ЗҮЙ ТӨЛӨВШИХГҮЙ, ЁС СУРТАХУУН ТӨЛӨВШИНӨ

Хүний хүлээх хариуцлага олон, тэдгээрийн дотроос “хүн байх” хариуцлага хамгийн гол нь. Үүнийг биелүүлвэл ямар мэдлэг боловсролтой, ажил, мэргэжилтэйгээс үл хамааран бусад хариуцлагыг хэрэгжүүлж чадна.



Б.ОЮУНЧИМЭГ

/Санхүү эдийн засгийн дээд сургуулийн багш, доктор (Ph.D), профессор/

Хариуцлага, бизнесийн нийгмийн хариуцлагын тухай өгүүлэхийн өмнө ёс зүй, ёс суртахууны талаар дурдахгүй байж болохгүй.

Амьдрал, ажил хэрэгтээ баримтлах зарчим, хэм хэмжээний тухай ярихдаа бид ёс зүй, ёс суртахуун гэсэн үгсийг хэрэглэдэг. Сүүлийн үед ёс зүй, ёс зүй гэгцгээх нь их болж. Ёс зүйгүй эмч, хүн ёс зүйтэй байх ёстой, ёс зүйгээ дээшлүүлье гэж ярьцгааж, ном, сонин хэвлэлд ч ингэж бичигцгээж байна. “Улс төрийн тойм” сонины 2010 оны тавдугаар сарын 27-ны өдрийн 073 дугаарын тавдугаар нүүрт “Монголын хамгийн өндөр цалинтай хүмүүс хамгийн ёс зүйгүй ажилладагийг МИАТ харууллаа” гэсэн шиг ёс зүй гэдэг үгийг буруу хэрэглэсэн жишээ цөөнгүй. Телевиз, радиогоор, кино, жүжигт ер нь хаа саагүй, дээр, доргүй, хэн хүнгүй ёс суртахууныг ёс зүй хэмээн ойлгон ярьж байна. Ажиглаад байхад ёс суртахуунлаг хүн, ёс суртахуунгүй ажилтан, ёс суртахуунаа дээдлэе, ёс суртахуун доройтож байна гэж зөв ярих хүн тун цөөн байх юм. Ёс зүй, ёс суртахуун гэж юу болох, эдгээр үгс юуг илэрхийлдэг, ямар утгатайг төдийлөн сайн ойлгож ухаараагүйгээс буруу зөрүү хэрэглэж бүр сурчихаад байна, бид.

Ёс зүй нь ёс суртахууныг судалдаг ухаан. “Ёс зүй бол итгүүлж үнэмшүүлэх гүн ухаан” гэж И.Кант, “Ёс зүй гэдэг нь хүн юу хийх, юунаас татгалзах ёстойг судалдаг ухааны нэр” хэмээн ёс зүйг үндэслэгч гэгддэг Аристотель хэлсэн нь бий. Ёс суртахуун нь ёс

зүйн ухааны судлагдахуун, хүнд байх учиртай, төлөвшүүлэх ёстой сайн сайхан чанаруудын нийлбэр цогц тул хүний ёс суртахууны тухай ярихдаа ёс зүй хэмээх шинжлэх ухааны нэрийг хэрэглэж, ёс зүйтэй хүн, ёс зүйгүй ажилтан гэх нь буруу юм. Ингэхийн оронд ёс суртахуунлаг хүн, ёс суртахуунгүй багш хэмээн хэлж ярьж, бичиж хэвших нь зүйд нийцнэ. Хүнд ёс зүй төлөвшихгүй, харин ёс суртахуун төлөвшинө, хүн ёс суртахуунтай байхаас биш ёс зүйтэй байхгүй. Хэн нэгнийг ёс зүйтэй хүн гэх нь ёс зүйн шинжлэх ухаантай хүн гэж байгаа хэрэг болно. Харин “ёс зүйн дүрэм” гэж хэрэглэж болох. Хүмүүст тавигдах ёс суртахууны шаардлага, мөрдөх зарчим, хэм хэмжээг тодорхойлон тогтоодог, сахиулан мөрдүүлдэг хүн ёсны хууль тул ийн нэрлэдэг.

Хүнийг судалдаг шинжлэх ухаан хэд хэд байдаг ч хүн өөрийгөө танин мэдэх замаар хөгжин дэвших, хүмүүжин төлөвших, хүн шиг хүн болох, хүн байхад туслах зорилготой ганц ухаан нь ёс зүй юм. Ёс зүй нь судлах зүйлээ онолын хийгээд практик талаас нь авч үзэж, шийдвэрлэж байдаг. Үүний учир шалтгаан нь ёс суртахууны шинжтэй асуудал хүний амьдралын бүхий л салбарт үүсэн бий болж байдаг оршдог. Ёс зүй нь нийгэм-хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой.

Ёс суртахуун улс төрийн харилцаанд хүмүүнлэг ба хүмүүнлэг бус, эдийн засгийн харилцаанд

шударга ба шударга бус, оюун санааны харилцаанд үнэнч ба үнэнч бус чанараар илэрч байдаг. Ёс суртахуун нь хүмүүсийн зайлшгүй баримталж хэрэгжүүлэх зарчим, дагаж мөрдөх зүй зохистой хэм хэмжээ юм. Ёс суртахуунлаг байна гэдэг нь зөвийг сурах, түүнийгээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа байнга мөрдөж хэвшүүлнэ гэсэн үг.

Хүн юуны өмнө өөрийнхөө, дараа нь гэр бүлийнхнийхээ, байгууллага хамт олныхоо, улс орныхоо өмнө хариуцлага хүлээдэг. Энэ бүх хариуцлагыг нийтэд нь нийгмийн өмнө хүлээх хариуцлага гэдэг. Хүний хүлээх хариуцлага олон, тэдгээрийн дотроос “хүн байх” хариуцлага хамгийн гол нь. Үүнийг биелүүлвэл ямар мэдлэг боловсролтой, ажил, мэргэжилтэйгээс үл хамааран бусад хариуцлагыг хэрэгжүүлж чадна. Хариуцлага жижиг зүйлээс эхэлнэ. Бага сага зүйлд хариуцлагатай бол том зүйлд ч хариуцлагатай байж чадна. Хариуцлага нь ажил үүргээ хариуцан биелүүлэх, харилцан тайлагнах, хариуцлага хүлээх, хүлээлгэх чадвар юм. Хууль бус, нийтийн ашиг сонирхолд харшилсан үйлдэл хийхээс татгалзах ёс суртахууны үүргээ гүйцэтгэх чадвар ч бас хариуцлага мөн.

Нийгмийн хариуцлага нь нийгмийн оролцоонд тулгуурлан хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх хандлага юм. Бизнесийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх талаар сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр эрчимтэй ярьж, бизнес зөвхөн ашгийн төлөө ▶

► байх ёсгүй гэж үздэг ч болж. “Ашгийг эцсийн зорилгоо болгосон бизнес хэзээ нэгэн цагт заавал дампууран мөхнө” гэж дэлхийд тэргүүлэгч “Форд” компанийг үндэслэгч Хенри Форд хэлсэн нь бий.

Бизнесийн нийгмийн хариуцлага гэдгийг явуулж буй үйл ажиллагаа, эдэлж буй эрх мэдэл, хийж буй ажил үйлчилгээнийхээ үр дүнгийн төлөө хамт олон, улс, нийгмийнхээ өмнө бизнесийн байгууллага, бизнес эрхлэгчийн үүрэг хүлээх, түүнийгээ хариуцах чадвар гэж тодорхойлж болох. Бизнесийн нийгмийн хариуцлага бол зүй ёсны, зайлшгүй хүлээх ёстой шаардлага, байгууллага оршин тогтнох үндэс юм. Хариуцлага хүлээдэггүй бизнесийн байгууллага оршин тогтнож эс чадна. Нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсартай биелүүлдэг байгууллага л амжилтад хүрдэг. Энэ талаар “Сүүлийн хагас зуун жилд дэлхий дээр бий болсон хамгийн хүчирхэг институци бол бизнесийн байгууллага юм. Аль ч нийгмийн тэргүүний институци нийтийн өмнө хариуцлага хүлээдэг...” гэсэн үг байдаг.

Бизнесийн байгууллага нь үйл ажиллагаагаа нийгмийн хөгжил дэвшилд чиглүүлэн тогтвортой явуулах, хөдөлмөрийн, санхүүгийн,

технологийн, гэрээний зэрэг бизнесийн сахилгыг сахих, бизнесийн үүрэг, хариуцлага, эрхийн нэгдлийг ханган ажиллах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах болон бусад хариуцлага хүлээнэ. Бизнесийн байгууллагынхны сахих ёстой сахилгуудын үндэс нь хөдөлмөрийн сахилга юм. Хөдөлмөрийн сахилга нь хөдөлмөрийн дотоод дэг журмыг мөрдөх, эрхэлсэн ажилдаа бүтээлч хандах, чанарыг эрхэмлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах явдал байдаг. Байгууллагын зохион байгуулалт муу, ажилтны нийгмийн идэвх сул, удирдлагын чадвар дулимаг, эдийн засгийн нөхцөл бүрдээгүй, дүрэм, журмаа мөрддөггүй, хүнд сурталтайгаас хөдөлмөрийн сахилга зөрчигдөх нь бий.

Компанийн нийгмийн хариуцлага гэдгийг өргөн утгаар нь үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй, нийгэм, байгаль орчин, эдийн засагтай уялдуулан явуулахыг хэлнэ гэж ойлгож болно. Компанийн нийгмийн хариуцлага нь улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмэр юм. Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйл ажиллагаагаа байгаль орчинд хор хөнөөлгүй, ээлтэйгээр эрхлэх, хэрэглэгчдийг хуурахгүй байх, тэдний эрх ашгийг дээдлэн хамгаалах, ил тод,

шударга өрсөлдөх, зар сурталчилгааг бодитой явуулах, ажиллагсдыг хөгжүүлэх, тэднийг ажиллах таатай нөхцөлөөр хангах, ашгийг эцсийн, цорын ганц зорилгоо болгохгүй байх нь компанийн нийгмийн хариуцлага. Богино хугацаанд, ямар ч хамаагүй арга замаар их ашиг олохын төлөө явах нь өнөөгийн бизнес эрхлэгчдийн ёс суртахуунд хамгийн их аюул учруулж байгаа.

Бизнесийн байгууллага ёс суртахууны алдаагаа засдаг байх ёстой. Байгууллага, албан тушаалтан нь ёс суртахууны хувьд хохирсон этгээдээс олны өмнө уучлал гуйх, ёс суртахууны ноцтой алдаа гаргасан ажилтныг ажлаас халах, хэрэглэгчийн хохирлыг барагдуулах, нийгмийн эрх ашиг, сонирхолд харшилсан, ёс суртахууны зарчмыг зөрчсөн шинжтэй бүтээгдэхүүн борлуулахаа болих, хэрэглээнээс хасах, ёс суртахуунд үл нийцэх аргаар хэрэглэгчдийг ятгасан сурталчилгааг зогсоох, байгууллагын ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлэх, дүрэм зөрчсөн ажилтанд хариуцлага хүлээлгэх замаар бизнесийн байгууллага ёс суртахууны алдаа, дутагдлаа засаж болно.

Ёс суртахууны үнэлэмж, баримжаагаа алдсан хүмүүс нийгэмд амьдарч байгаа ч нийгэмтэй холбоо харилцаагүй болж, тун явцуу хүрээнд орж, амин хувиа хичээж, бүдүүлэг хэрэгцээнд дарлуулж, зөвхөн өнөөг харсан ахархан сэтгэл гаргаж, энэ байдлаараа ашиг сонирхол гүйцэлдүүлэхэд хүрдэг гэж Францын судлаач Э.Дюркгейм ёс суртахуунгүй хүний талаар тун ч оновчтой хэлсэн байдаг. Хэн хүнд, түүний дотор бизнес эрхлэгч хүнд ёс суртахуун ямар их хэрэгтэй зүйл болохыг энэ үгнээс ухаарч болно. Бизнес эрхлэгч нь хүн шиг хүн байж чадвал бизнесээ амжилттай эрхэлж чадна. Ингэхлээр бизнес эрхлэгчийн, бизнесийн байгууллагынхны хүлээх нийгмийн хариуцлагын үндсийн үндэс нь хүн байх явдал болж байна. Хүн шиг хүн байна гэдэг нь бусдад саад бэрхшээл учруулахгүй, хохироож зовоохгүй, өдөр тутмын амьдрал, ажил хэрэгтээ бусдын өмнө хариуцлага хүлээж, бусдын төлөө байж чадах явдал юм. ■



ЭРҮҮЛ АМЬДРАХЫН НУУЦ НЬ ЭРҮҮЛ ШҮД

Нийслэлийн иргэдэд шүдний эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх гол ажлыг Шүд эрүү нүүрний эмгэг судлалын үндэсний төв болон дүүргүүдийн эмнэлэг нугалдаг байна.

Б.УУГАНБАЯР

Хүн бие нь өвдөөгүй үедээ хэзээ ч өвдөхгүй юм шиг бодож биеэ зөнд нь орхидог. Өөрийгөө ч анзаарах сөхөөгүй явсаар нэг л өдөр өвдөх нь бий. Тэгвэл бидний гадаад гоо сайхнаас эхлээд хоол боловсруулах эрхтэн, ходоод гэдэс, зүрх бөөр, хоолой гээд бүх эрхтэний эрүүл байх үндэс нь эрүүл, сайхан шүдтэй байх гэдгийг эмч нар сануулдаг.

Өнөөдөр манай улс шүдний өвчлөлөөрөө дэлхийд толгой цохиж буй нь судалгаагаар тогтоогджээ. ЭМШУИС-ийн Нүүр, ам судлалын сургуулиас өнгөрсөн онд хийсэн судалгаагаар манай улсын хүн амын 86.5 хувь нь цоорхой шүдтэй гэсэн дүгнэлт гарчээ. Мөн хот, хөдөөд өрнөсөн “Эрүүл хүүхэд” аяны хүрээнд хийсэн үзлэгээр 18 нас хүртэлх хүүхдүүдийн 91 хувь нь шүдний өвчлөлтэй гарсан байх жишээтэй. Тэгэхээр манай улсын 10 хүн тутмын нэгийнх нь л шүд эрүүл байх магадлалтай гэсэн үг. Шүдний өвчлөл өндөр байгаагийн шалтгааныг Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийн захирал Д.Чухал хэлэхдээ “Бид судалж үзэхэд шүд цоорох гол шалтгаан нь хоол хүнсэндээ хийжүүлсэн ундаа, чихэрлэг зүйл их хэрэглэдэг болон амны хөндийн эрүүл мэндээ анхаардаггүйтэй холбоотой” гэв. Ялангуяа бага насны буюу 5-6 настай хүүхдүүдийн 90 орчим хувь нь шүдний өвчлөлтэй байгаа юм. Өсвөр нас, насанд хүрээд ирэх үед өвчлөлийн хурд саарч ажиглагджээ. Тэгэхээр хэрэв хүүхдийнхээ шүдийг багаас нь зөв арчилж, амны хөндийн эрүүл мэндээ сахих зөв

дадалд хэвшүүлэх юм бол өвчин зэрэхгүй гялалзаж явах нь ээ.


Шүд үрвэссэнээс ходоод гэдэс, бөөр өвдөж эхэлдэг

Нийслэлчүүдэд шүдний эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх их ажлын голыг нь Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төв болон дүүргүүдийн эмнэлэг нугалдаг байна. Жишээ нь Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв өдөрт 40 орчим хүнд эмчилгээ хийх, 70 хүнд шүд авах үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай юм байна. Гэтэл эмнэлгийн ажилтнуудын хэлж буйгаар, шүдэндээ эмчилгээ хийлгэх хүсэлтэй хүн харьцангуй олон байдаг тул иргэд тухайн өдрийн эмчилгээнд багтахаар үүрийн 04.00 цагаас эхэлж, эмнэлгийн үүдэнд урт дараалал үүсгэх нь олонтаа. Тэгвэл энгийн тооцоо хийгээд үзэхэд зөвхөн тус эмнэлэгт л гэхэд өдөрт 70 хүн шүдээ авахуулдаг гэж бодоход / амралтын өдрийг оруулалгүй/ сард 350, жилд 4200 хүн шүднээсээ “салдаг” байна. Үүний цаана хувийн 270 орчим шүдний эмнэлэг мөн байнгын үйлчлүүлэгчтэй гээд бод доо. Тоймгүй тоо гарна. Шүд өвчилсөнөөс ямар өвчлөл үүсдэг талаар Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийн эмч Д.Нямсүрэн хэлэхдээ “Хүний бие эрүүл байх эх үндэс нь эрүүл шүдтэй байх эсэхээс шууд хамаардаг. Хэрэв шүд хорхойтож, буйл үрэвсэж эхэлбэл ходоод, гэдэс хямрахаас эхлээд бөөр үрэвсэж, элэг өвдөж, үүнийгээ

дагаад хоолойны ангинатай болж, зүрх дэлсэж эхэлдэг. Тиймээс хүний эрүүл байхын үндэс нь шүдээ зөв арчилж, хамгаалж байх” гэв.

Кальци дутагдсанаас хүүхдийн шүд эмтэрч, үйрдэг

Сүүлийн үед хүүхдүүд шүдний хатуу эдийн төрөлхийн гэмтэлтэй төрж буйг “Хэрмийн цахиур” шүдний эмнэлгийн согог засалч эмч Ж.Ганчимэг хэлсэн. Ингэж хүүхэд төрөхдөө шүд нь хатуу ▶



Эх сурвалж: “Улаанбаатар хотын хүүхэд залуусын амны хөндийн өвчлөлийн судалгаа 2011” номноос

▸ эдийн гэмтэлтэй байвал сүүн шүд нь амархан үйрч эмтэрдэг, цаашлаад шүд нь ургахаараа муруй хазгай болдог байна. Тиймээс жирэмсэн эхчүүд энэ тал дээр анхаарч, эрүүл биетэй, сайхан шүдтэй хүүхэдтэй больё гэвэл кальци хэрэглэж, жирэмсэн байх үедээ тэжээллэг хоол хүнс сайн хэрэглэх ёстой аж. Дээр нь эмч

нарын санал болгож буйгаар шүдээ эрүүл байлгах хамгийн энгийн арга нь шүдээ зөв угаахаас 30 хувь нь хамаардаг байна. Тэгэхээр эмч нарын зөвлөгөө бол та хүүхдийнхээ шүдийг нэг нас хүрсэнээс нь хойш жилд хоёр удаа байнга мэргэжлийн эмчид хандан, зөвлөгөө авч байх хэрэгтэй. Мөн хүүхдийнхээ цахиур нь цухуйж эхлэхэд нь содтой усаар

арчих ёстой юм байна. Дараа нь нэг нас хүрснээс хойш өөрт нь тохирсон зөөлөн үстэй сойз, зориулалтын оо авч зургаан нас хүртэл нь эцэг, эх нь угааж өгөх ёстой. “Эрүүл биед саруул ухаан оршино” гэдэг. Тэгэхээр эрүүл биетэй, саруул ухаантай, сайхан амьдрахын тулд өнөөдрөөс өөрийгөө өөрчилж, дээрх энгийн зүйлийг мөрдөж эхлээрэй.

e e ee



Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийн дарга Д.Чухал, тус төвийн эмч Д.Нямсүрэн, “Хэрмийн цахиур” шүдний эмнэлгийн согог засалч эмч Ж.Ганчимэг нарын шүдээ өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөөг хүргэе.

-Хийжүүлсэн ундаа уухдаа байнга соруул хэрэглэж, шүдэндээ хүргэхгүй байвал шүдний паалан гэмтэхгүй

-Гурилан бүтээгдэхүүн, амттан идсэний дараа заавал араас нь ус эсвэл шингэн зүйл ууж байх

-Хүүхдээ аль болох аягыг нь долоолгох эсвэл хэлийг хамрын үзүүрт хүргэх дасгалыг хийлгэж байвал тультраа эсвэл шүд муутай болохгүй

-Хоол идэхдээ хоёр талаараа ээлжилж зажилж байвал шүд эрүүл байна

-Хүүхдээ нэг нас хүрэхэд нь шүдний эмчид хандан зөвлөгөө авч, зургаан сар тутамд үзүүлж занших

хэрэгтэй

-Хүний биед өдөрт 1000 мг кальци шаардлагатай байдаг бол жирэмсэн эхийн биед 1500 мг кальци хэрэгтэй байдаг. Ингэхдээ D3+Magni орсон кальцийг хэрэглэх илүү үр дүнтэй.

-Хүүхдийнхээ амыг содтой усаар өдөрт гурван удаа зайлж заншвал шүд гэмтэх болон амны хөндийн өвчлөл үүсэхгүй

-Шүдний дотор талаа байнга угааж заншаагүйгээс шүдний чулуу үүсдэг ■

ЕВРОПЫН НИЙГМИЙН ЗАГВАР ГЭЖ ЮУ ВЭ?

Хөгжлийн загварын тухай цуврал №3
Түрүүч нь 2012 он 07 сар №12 (022) дугаарт

Б.ЭНХМАНДАХ Доктор /Ph.D./



Дээр бидний авч үзсэн Амьдралын Америк замаас эрс ялгаатай Европын нийгмийн загвар гэж юу байдаг талаар товч авч үзье.

Европын нийгмийн загвар /European social model/ гэдэг нь Европын олонхи оронд амьдралын өндөр стандарт, ажиллах сайн нөхцөлийг эдийн засгийн өсөлттэй хослуулсан нийгмийг төлөвшүүлэх тухай нийтлэг төсөөллийг тодорхойлоход хэрэглэгддэг ойлголт юм.

Европын хувьд улс орон бүр өөр өөрийн гэсэн нийгмийн загварыг хэрэглэдэггүй бөгөөд Европт бүх нийтийн сайн сайхан нийгэм /welfare state/ байгуулах үйл явц нь түгээмэл хэд хэдэн шинжтэй байдаг байна. Бүх нийтийн засаглал, иргэн бүрийн нийгмийн оролцоо, нийгмийн хамгаалал болон ажлын байрны төгс хүрэлцээг хангах нь Европын улс орон бүрийн хувьд нийтлэг зорилт болсон байна. Тухайлбал, Европын Холбооны Гэрээнд ажлын байрыг хөхиүлэн дэмжих, амьдралын болон ажиллах нөхцлийг сайжруулах, удирдлага, ажиллагсдын хоорондын харилцан ойлголцлыг хангах, хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн хамгаалалыг төгөлдөржүүлэх зэрэг нийгмийн зорилтуудыг тавьсан байдаг байна. Ингэхдээ Европын улс орон бүр хөгжлийн өөр өөр асуудалд илүүтэй анхаарч ирсэн байдаг аж.

Иймээс Европт Англо-Саксон, Эх газрын, Газрын дундад тэнгисийн болон Умардын гэсэн нийгмийн дөрвөн загвар байдаг гэж эрдэмтэд үздэг.

Ер нь Европын нийгмийн загвар нь Дайны дараах сэргэлттэй холбоотой гэж үздэг. Үүнд, судлаачид протекционизмын сулралт, төрөлт эрс нэмэгдсэн, хямд эрчим хүч, АНУ дахь сэтгэл ханамж бүхий амьдралын түвшинг гүйцэх хүсэл эрмэлзлэл зэрэг хүчин зүйлүүдийг нэрлэдэг байна. Европын нийгмийн загвар нь нөгөө талаар олон улсын эдийн засгийн интеграцид хамрагдаж амжаагүй Зөвлөлтийн эвсэл болон Хятад, Энэтхэгийн гадаад өрсөлдөх чадвар сул байснаар нөхцөлдөж байсан гэж үзэж болно.

Харин сүүлийн жилүүдэд даяаршил (globalisation), Европчлогдох үйл явц (Europeanisation) болон хүн амын өсөлт (ageing population) зэргээс хамаарч, Европын нийгмийн загвар хэр тогтвортой бол гэсэн асуудал үүсч байгаа нь нууц биш ч хөгжлийн энэ загварыг судлах нь хөгжиж буй орнуудын хувьд ач холбогдолтой хэвээрээ байна.

Хөгжлийн Европын загварын хувилбаруудыг тус бүрээр авч үзвэл:

Англо-саксоны загвар

Их Британи, Ирландад хэрэглэгддэг Англо-саксоны загвар нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын өндөр орлоготой орнуудын дундаж түвшинд хамаарах, Умардын гэхээсээ илүүтэй Эх газрын Европын загварт илүү дөхүү нийгмийн бүдүүн бараг загвар гэж хэлж болно. Европын бусад олонхи орныг бодох юм бол эдгээр орнууд хэдийгээр ДНБ-ий харьцангуй өндөр өсөлттэй, ажилгүйдлийн түвшин бага хэдий ч ядуурал, тэгш бус байдалд нэрвэгдсээр байдаг. Баруун Европын ихэнх орнуудыг бодвол нийгмийн хамгаалал сул тул ИБУИНВУ, Ирландад улсын орлогыг хуваарилж, амжиргааны доод түвшинг хангахуйц орлогыг баталгаажуулж, эмнэлгийн үйлчилгээний хувийн төлбөрийг хөхиүлдэг байна.

Эх газрын Европ загвар


Австри, Франц, Герман, Бельги болон Люксембургт хэрэглэгддэг энэхүү загвар нь ажлын байрыг хамгаалахад илүүтэй чиглэгдсэн байдгийн зэрэгцээ аж үйлдвэрлэлийг нарийн зохицуулсан зохицуулалттай байдгаараа онцлогтой аж. Гэхдээ, хөдөлмөрийн зах зээл нь уян хатан бус тул даяаршилд удаан дасан зохицдог байна. Даатгалд тулгуурласан ажилгүйдлийн тэтгэмж, төрийн санхүүжилтэд тулгуурласан нийгмийн сайн хамгаалал нь ядуурлыг бууруулж, эмнэлгийн үйлчилгээг чанартай байлгахад түлхэц болдог. Энэ загварыг ерөнхийдөө Англи-саксон болон Нордик загваруудын дундын хувилбар гэж үздэг байна.

Газрын дундад тэнгисийн загвар

Итали, Испани, Грек, Португал зэрэг орнуудад хэрэглэгддэг Газрын дундад тэнгисийн загвар нь Эх газрын загварын нэгэн адил улсын тэтгэвэрт тулгуурласан нийгмийн хамгаалалд төвлөрдөг байна. Хөдөлмөрийн зах зээл нь Их газрын нэгэн адил ажлын байрны хамгаалалтай зохицож өгдөггүйн зэрэгцээ нийгмийн халамжийг хамгийн доод түвшингээр тооцсон байдаг нь дутагдалтай гэнэ.

Харин Нордик буюу Умардын загварыг Европын нийгмийн загваруудын хамгийн шилдэг нь хэмээн үздэг байна. Энэ загварын талаар жич тодруулан авч үзэх болно. ■

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА МАРКЕТИНГИЙН АРГА ХЭРЭГСЭЛ БИШ



Х.ХУЛАН

Монгол Улсын экспортын 98.6 хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзлэх болсон үед уул уурхай эдийн засгийн хөгжлийн түлхүүр хүч нь болж байна. Харин энэхүү түүхэн эрин үед хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь нэн тэргүүний асуудал юм. Экологийн доройтол, баялгийн хараалаас зайлсхийж тогтвортой хөгжлийн чиглэлийг сонгоход КНХ томоохон үүрэгтэй. Сүүлийн үед дэлхий дахинаа компанийн нийгмийн хариуцлага гэж тод томруунаар ярих болсон. Ярихаас ч аргагүй болж буй. Учир нь, КНХ аливаа бизнесийн урт удаан хугацаанд оршин тогтнох үндэс суурь нь юм.

Германд нийгмийн хариуцлагатай компаниуд байгаль орчинд үлдээх үл мөрөө багасгаж, хөдөлмөрийн хуулийн дүрэм журмыг мөрдөн ажиллахын сацуу нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулж байна. Компанийн нийгмийн хариуцлагыг аль ч оронд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл,

хуульчлаагүй байдаг. Германы компаниуд нийгмийн хариуцлагын стратегийг ихэнх тохиолдолд үйл ажиллагаатайгаа уялдуулан боловсруулсан ажиглагдсан. Гэхдээ КНХ-ын асуудалд бизнес төдийгүй улс төрийн зүгээс ихээхэн анхаарч, дэмжлэг үзүүлдэг байна. Үүний нэг жишээ бол “Герман дахь КНХ” үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Германы Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлдэг энэхүү стратегид ЖДҮ-ийг хэрхэн нийгмийн хариуцлага сайн биелүүлдэг болох тал дээр онцгой анхаарч байна. Мөн КНХ-ыг Германд нийгэм, байгаль орчин, эдийн засаг гэсэн гурван тулгуурт суурин дээр авч үздэг аж.

Германы томоохон компаниудын ажиллагсад иргэний үүргээ ухамсарлаж, сайн дурын үндсэн дээр нийгэмд хувь нэмрээ оруулж буй нь шинэлэг юм.

Манай оронд КНХ-ыг соёл урлаг, спортын үйл ажиллагааг дэмжих,

хандив тусламж өгөх төдийхөнд ойлгох нь бий. Энэ нь хэтэрхий явцуу ойлголт юм. Гэхдээ энэ ойлголтыг зарим томоохон компанийн төлөөлөл эвдэж сонгодог утгаар нь ойлгож ажиллах хандлага сүүлийн үед бий болж байгаа нь сайн талтай. Мөн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд гүйцэтгэсэн ажлаа дөвийлгөж, байгууллагын сурталчилгаандаа ашигладаг. Гэтэл КНХ гэдэг нь маркетингийн хэрэгслээс ангид байх ёстой зүйл. Хандив тусламжаас хамаагүй өргөн хүрээтэй энэхүү ойлголтыг зөв хэрэгжүүлэхийн тулд эхлээд компанийнхаа үнэт чанарыг сайтар ойлгох хэрэгтэй. Компаниуд том, бага хэмжээнээсээ үл хамааран КНХ-ын өөрийн гэсэн стратеги төлөвлөгөөг бизнесийн үйл ажиллагаандаа “шигтгэн” өгөх нь ихээхэн ач холбогдолтой. Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нь зөвхөн нийгэм, байгаль орчиндоо бус, хамгийн гол нь тухайн компанид өөрт нь ашигтай зүйл юм.

ХЭРЭГЖҮҮЛЭЭД ЭХЭЛСЭН БАЙХАД АМЖИЛТЫН ХААЛГА НЭЭГДЭНЭ



Роберт Хубер, Карлсруэ хотын ХАҮТ-ийн Олон улсын эдийн засгийн зөвлөлийн дарга

ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрөөс санаачлан зохион байгуулсан Германы тэргүүлэх компаниудын нийгмийн харууцлагын туршлагатай танилцах аяллын талаар сэтгүүлийн өмнөх хоёр дугаарт дэлгэрэнгүй бичсэн билээ. Харин энэ удаа Карлсруэ хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гадаад эдийн засгийн зөвлөлийн дарга Роберт Хубертэй хийсэн ярилцлага болон аялалд оролцогчдын сэтгэгдлийг хүргэж байна.

Германы мэдээллийн технологийн бүс болсон Карлсруэ хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхим дээр зочиллоо. Энэхүү айлчлалын үеэр Германы бизнес эрхлэгчид Монголын уул уурхайн төлөөлөгчидтэй уулзаж санал бодлоо солилцож, туршлагаа хуваалцсан нь ихээхэн ач холбогдолтой байлаа. Тус танхимын Олон улсын эдийн засгийн зөвлөлийн дарга Роберт Хубертэй товч ярилцсанаа хүргэж байна. Тэрбээр энэхүү албан тушаалаа 12 жил хашиж байгаа бөгөөд нийтийн тээврийн хангамж хариуцсан хувийн компанитай аж. Англи, франц хэлээр сайн ярьдаг тэрбээр итали хэлний зохих хэмжээний мэдлэгтэй.

-Танай танхим бизнес эрхлэгчдээ хэрхэн дэмжиж ажилладаг вэ? Танхимаас хамгийн сүүлд зохион байгуулж буй үйл ажиллагаанаасаа сонирхуулна уу?

-Манай танхим 65 мянган гишүүн компанитай. Карлсруэ хотын ХАҮТ нь гишүүдийнхээ эдийн засгийн эрх ашгийг хот, муж, улсын хэмжээнд төлөөлөх үүргийг гүйцэтгэдэг. Мөн гишүүн компаниудад экспорт хийх нөхцөл боломжоор хангаж, тэдгээрийг гадаадын зах зээлд хөл тавихад нь дэмждэг. Залуучуудын сурч боловсрох, тэдгээрийг ирээдүйн мэргэжилд нь бэлтгэхэд анхаардаг. Карлсруэ хотын болон ойролцоох найман их сургуультай хамтран ажилладаг. Хамгийн сүүлд "Шинэчлэл- аллианс" нэртэй санаачлагыг хэрэгжүүлж эхэлсэн. Тус санаачлагын хүрээнд технологийн шинэчлэл, үйлдвэрлэлийн шинэ систем гаргах, зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, шинжлэх ухааны ноу-хау чиглэлээр гаргасан шинэ санааг дэмжих юм. ХАҮТ-тай хамтрагч байгууллагууд нь Фраунхофын институт, Карлсруэ хотын Техник, эдийн засгийн дээд сургууль, Мэдээлэл зүйн судалгааны төв юм.

-Та манай сэтгүүлийн уншигч бизнес эрхлэгчдэд ямар зөвлөгөө өгөх вэ? Бизнесээ амжилттай явуулахын тулд тэд юун дээр анхаарвал зохистой вэ?

-Боловсролын асуудал хамгийн чухал. Дэлхий даяар явагдаж буй даяаршилтай уялдан залуучууд өрсөлдөх чадвартай байх ёстой. Үүний тулд боловсрол, сургалтын асуудалд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Ийм л зөвлөгөө өгье. Хэрэгжүүлээд эхэлсэн байхад, амжилтын хаалга баталгаатай нээгдэх болно.

-Уул уурхайн салбар хүчтэй хөгжиж байгаа Монгол Улс эдийн засгаа олон тулгууртай хөгжүүлэхийн тулд юуг анхаарвал зүгээр вэ?

-Уул уурхай бол хязгаартай бүтээгдэхүүн. Эрдэс баялаг, үнэт металлын нөөц дууссан үед улс үндэстэн юу хийх вэ гэдгээ урьдчилж мэдсэн байх хэрэгтэй. Өнөөдөр бид мэдлэгт суурилсан нийгэмд амьдарч байна, энэ нь юу хийх вэ гэдгийг хэлээд өгч байгаа. Олон жил тогтвортой эдийн засагтай байхын тулд мэдлэгт тулгуурлах ёстой.

-Герман Улс ногоон эдийн засгаар алдартай. Карлсруэгийн ойролцоох Фрайбург хот жишээ нь нарны эрчим хүчээрээ нэрд гарсан.

-Маш сонирхолтой асуудал. Баден-Вюрттембергийг эрчим хүчээр дагнасан муж гэж хэлж болно. Карлсруэгийн Технологийн институт эрчим хүчний үр өгөөжтэй байдал сэдвээр чухал судалгаа шинжилгээ хийдэг. Улсын хэмжээнд эрчим хүчний асуудлаар тэргүүлдэг байгууллага. Германд эрчим хүчийг үр өгөөжтэй ашиглах томоохон боломж бий шүү.

-Ногоон эдийн засагт шилжих эхний алхам юу вэ?

-Эрчим хүчний үр өгөөжтэй байдал. ■

PMONGOLIAN ECONOMY

Германы КНХ-ын туршлага аяллаас Та юу харсан бэ?

Ж.Сүнжидмаа, Монгол дахь “Пийбоди Энержи” компанийн Нийгмийн хариуцлага, Олон нийттэй харилцах менежер:



-Даяарчлагдсан дэлхийд компаниуд үйл ажиллагаа явуулахдаа нийгэмд хариуцлагатай байх шаардлага улам хурцаар тавигдаж байгааг энэ аяллаас сайн ойлгож авлаа. Ялангуяа дэлхийн томоохон хөгжилтэй орны хувьд Германы компаниуд нийгмийн асуудалд, тухайлбал, байгаль орчин, боловсрол, эрүүл мэндэд ихээхэн хувь нэмрээ оруулж байна. Энэхүү хувь нэмэр нь нийгэмд шаардлагатай үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, хэрэгтэй эх үүсвэрүүдийг хангахаас гадна тухайн компанийн үйл ажиллагаа бүхэлдээ нийгэм, байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр явуулж байгаагаар тодорхой илэрч байна.

Нөгөө талаас амжилттай бөгөөд олон зуун жилийн хугацаанд тогтвортой хөгжиж байгаа компаниудийн нийгэмд хариуцлагатай байх үзэл баримтлал олон зуун жилийн уламжлалтай байна. Тодруулбал “Бош” компани. Энэ нь Америк компаниудын филантроп үзэл олон жилийн өмнө үүссэн хөгжилтэй адилхан юм байна.

Рик Блэйк, “Сентерра гоулд Монголиа” компанийн Хүний нөөцийн хэлтсийн захирал:




-Германы компаниудын нийгмийн хариуцлагатай танилцах аяллын явцад хэд хэдэн зүйл онцгой сэтгэгдэл төрүүлсэн. Тухайлбал, Германы Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэн КНХ-ын бодлогыг тодорхойлох, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, түүндээ хяналт тавихад хамтран ажиллаж чадсан байна.

КНХ гэдэг нь хоосон үг хэллэг төдий зүйл биш, харин ч компанийн эрхэмлэх зүйл болон үйл ажиллагааны стратеги чиглэлд тодорхой тусгагджээ.

Компанийн зүгээс нийгэм олон нийтэд эдийн засаг, байгаль орчин, нийгмийн чиглэлээр үзүүлж буй нөлөөллийн бүх хэлбэртэй холбоотой хэрэгжиж байна. КНХ нь компанийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд ч тодорхой тусгалаа олжээ. Ялангуяа гадаад улс орноос түүхий эд, бараа, материал авч байгаа эсвэл гадаад улс оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд үүнд онцгой анхаарч ажиллаж байх жишээтэй. Түүнчлэн компаниуд КНХ-ын талаар хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг тооцох, олон улс, харилцагчдадаа мэдээлэх тал дээр ихээхэн анхаарал хандуулж байна. Зарим компаниуд КНХ-ын тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлыг сонгох, төлөвлөхөд оролцдог КНХ-ын Зөвлөлдөх зөвлөлийг ажиллуулж байна.

www.mongolianeconomy.mn

О.Батболд, ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн Засаглал, КНХ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн:




-ГОУХАН-ын ЭТИС хөтөлбөр түншүүдтэйгээ хамтран КНХ-ыг Монгол Улсад хөгжүүлэх чиглэлээр олон төрлийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Эдгээрийн нэг нь уул уурхайн компаниудын КНХ-ын асуудал. Бид энэ чиглэлээр компаниудын хэрэгцээ шаардлагад үндэслэн тодорхой үйл ажиллагаануудыг өнгөрсөн хугацаанд зохион байгуулсан бөгөөд эдгээрийн нэг нь өнгөрсөн оны зургадугаар сард ХБНГУ руу “Германы КНХ-ын туршлага” сэдэвт аяллыг хийлээ. Аялалд манай хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог төрийн болон хувийн өмчит мөн гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниудын мэргэжилтнүүд оролцож, Германы КНХ-ын талаар газар дээр нь танилцахаас гадна дэлхийд танигдсан топ компаниудын нийгмийн хариуцлагын туршлагаас хуваалцсан. Тэр дундаас өөрийн компанид таарч тохирсон шинэлэг санааг авах, цаашид энэ чиглэлээрээ очсон байгууллагууд, компаниудтай холбоо тогтоон ажиллах боломж бүрдсэн юм.

Д.Одон, “Професи коал” компанийн Засгийн газартай харилцах зөвлөх:



-“Компанийн нийгмийн хариуцлага” гэсэн нэр томъёо шинээр орж ирж, хүмүүс янз янзаар ойлгож буй бөгөөд энэ нь Монголд ч Германд ч түгээмэл байгаа нь мэдрэгдэж байлаа. Гэхдээ хүмүүс үүнийг зөвхөн нийгмийн асуудал руу хэт түлхүү чиглүүлж, зөвхөн нийгмийн халамж, хандив тусламж гэх зэргээр “орчуулж” энэ чиглэлийг нь дөвийлгөж байгаа юм шиг. Гэтэл үүний цаана компанийн тогтвортой хөгжил, аюулгүй ажиллагаа, хууль дүрмийн хүрээнд бүх үйл ажиллагаагаа явуулах, түүний дотор хангамж худалдан авалт, хүрээлэн буй орчин (ялангуяа уул уурхайн салбарт), цаашилбал авлигатай тэмцэх гэх олон талт асуудал багтаж буйг зохих төвшинд анхаарч үзэхгүй байгаа юм шиг санагддаг. Германы туршлагаас харахад, энэ асуудалд ул суурьтай хандах, нэгдсэн нэг стратеги баримтлан ажиллаж байна. Үүний дагуу төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж, зохих үйл ажиллагаа явуулах нь Монголын нөхцөлд нэн тэргүүний авч хэрэглэх чухал тэргүүн туршлага юм байна гэж ойлгосон. ■

ШИНЭ НОМ



УХААН БОДЛОО ТЭЛЖ, ҮГ ХЭЛЭЭ ХУРЦАЛ

Манай өвөг дээдэс эрт дээр үеэс үр хүүхдүүдээ сургаж, хүмүүжүүлэхдээ зүйр цэцэн үгийг өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг мэргэн ард түмэн билээ. Тиймээс ч “Цэцэн үг цээлээс, зүйр үг зүүнээс хурц” хэмээн хэлсэн байдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд даяарчлалын нөлөөгөөр хүмүүсийн сэтгэхүй, хандлага өөрчлөгдөж уламжлалт ёс заншил, үгийн уран цэцэн хэллэгийг мартаж дөхөж буй. Энэхүү гайхамшигт өв уламжлалаа хойч үеийнхэн залуустаа сурталчилж, ажил амьдралдаа тодорхой хэмжээгээр мөрдлөг болгохыг уриалж “Номин” холдингийн зөвлөх Худалдааны гавьяат ажилтан, А.Шагдарсүрэн өөрийн гурван хүүтэйгээ хамтарч “Монгол ардын зүйр цэцэн үгийн хоймсон хураангуй” хэмээх номыг гаргажээ. Ингэхдээ тус номонд манай ард түмний нийтлэг хэрэглэж ирсэн зүйр цэцэн үгийг цагаан толгойн дарааллаар байршуулж, хадмал монгол бичгээр давхар орчуулж өгснөөрөө онцлог аж. Тиймээс Монгол хэлнийхээ уран яруу үгсээ хэлхсэн тус номоор ухаан бодлоо тэлж, үг хэлээ хурцалж байхыг номыг эмхлэн гаргачид уриалжээ. Тус номноос таны бодлыг хөрвүүлж, ухааныг сийрүүлэх зарим үгийг доор сонирхуулъя.

Мянган хүний зүс танихаар
Нэг хүний нэр цээжил
Мэдэхгүй гэсэн мэл сохор
Чадахгүй гэсэн таг сохор
Нүдний сохроос
Цээжний сохор хэцүү
Сайн хүн өөрийн гэмийг
шинждэг
Саар хүн бусдыг
гэмийг шинждэг



“ЭХЧҮҮДИЙН ХҮҮХДЭЭ ХӨХҮҮЛЭХИЙГ ДЭМЖИХИЙН УЧИР”

Манайд жилд дунджаар 70 мянга орчим эх амаржиж, үрийн зулай үнэрлэдэг гэсэн тоо бий. Гэвч хүүхдийг эхийн сүүгээрээ хооллох тохиолдол төдийлэн хангалтгүй байдгийг эмч нар шүүмжилдэг. Тэгвэл Хоол судлалын тэргүүлэх эрдэмтэн М.Оюунбилэг, Хоол судлалын төвийн захирал Ж.Батжаргал нарын хамтран бичсэн “Эхчүүдийн хүүхдээ хөхүүлэхийг дэмжихийн учир” номыг та бүхэнд танилцуулж байна. Хүүхдийг эхийн сүүгээр хооллосноор хүүхдийн амьдрах чадвар сайжирч, эхийн эрүүл мэндэд ч тустайн сацуу төрөлтийг ч холдуулдаг болохыг сүүлийн 10 жилийн хугацаанд хийсэн судалгаагаар тогтоожээ. Мөн эхийн сүүгээр хооллосон хүүхэд угжаар өсгөсөн хүүхдээс оюуны чадавхын түвшин өндөр, аливаа зүйлд хандахдаа тайван, биеийн өсөлт, хөгжил сайтай байдаг аж. ДЭМБ-ын судалгаагаар хөгжиж буй орнуудын нялхасын эндэгдэлийн нэг шалтгаан нь суулгалт өвчин болон амьсгалын замын өвчнөөс шалтгаалдаг аж. Жишээ нь, эхийн сүүгээр хооллосон 100 хүүхдийн нэг нь, угжаар өссөн 100 хүүхдийн 20 нь суулгалтаар өвддөг гэжээ. Түүнчлэн угжаар өсгөсөн хүүхэд насанд хүрээд таргалах, чихрийн шижингээр өвчлөх магадлал өндөр байдаг гэнэ. Мөн хөхөөр хооллосон хүүхдийн эхийн эрүүл мэндэд ч сайн нөлөөтэй байдгийг тогтоосон дотоод, гадаадын судалгаа

бишгүй. Тиймээс залуу эхчүүд тус номыг ширээний номоо болгож, эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлж, хүүхдээ хөхөөр зөв хооллох талаар суралцах боломжтой юм.



“ӨӨДРӨГ ҮЗЛИЙН ҮР”

Солонгосын зохиолч Ким Хён Тэ өсвөр насныхүүхэд залууст зориулсан амьдралаа өөдрөгөөр харж, эрч хүчтэй урам зориг, хүсэл тэмүүлэл дүүрэн амьдрахыг уриалж “Өөдрөг үзлийн үр” хэмээх номыг бичжээ. Ингэхдээ өөдрөг үзлийн 14 үрийг тодорхойлон гаргаж, сонирхолтой жишээ, зургаар чимж танилцуулжээ. Сайн үр сайн жимс ургуулдаг шиг бага байхдаа амьдралынхаа үрийг бат бэх, зөв хандлагатай тавьж чадвал хүний амьдрал үргэлж дээшилж, өөдрөг явна гэдгийг номын зохиолч онцолсон. Ялангуяа хүсэл мөрөөдөлтэй байх, түүндээ хүрэхийн төлөө чин сэтгэлээсээ тасралтгүй тэмцэж, тэмүүлж чадвал мөрөөдөл заавал биелнэ. Түүнчлэн өөрийнхөө бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, аливаа зүйлийг шантралгүй туршиж үзэж, өөрийнхөө давуу хийж чадах зүйлийг олохын төлөө тэмүүлж байхыг хүүхдүүддээ уриалсан. Мөн үргэлж номтой нөхөрлөж, өөрийн цагийн зохион байгуулалтаа бага гэлтгүй анхаарч, өөрийгөө хөгжүүлэх зөв зүйлд цагаа зарцуулж, эх орондоо хэрэгтэй ухаантай хүн болохыг номын зохиогч учирлажээ.